



ZSL | **LET'S WORK
FOR WILDLIFE**

ЛОНДОНГИЙН АМЬТАН СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГ

МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТАЙЛАН
2018 - 2020



ЛАСН
Монгол дахь төлөөлөгчийн газар

Монгол Улс,
Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу - 47,
Монреимпекс Билдинг,
302 тоот.

Утас: 7711 1138
И-мэйл: Tungalag.Ulambayar@zsl.org

ГАРЧИГ

1 ЗОРИЛТОТ ЗҮЙЛ 4

- 1.1 Хавтгай 6
 - 1.1.2 Усны хомсдол ба чанарын судалгаа 8
 - 1.1.3 Хүний нөлөө ба бэлчээрийн давхцал 9
 - 1.1.4 Автомат камерын судалгаа 10
- 1.2 Монгол тарвага 16
- 1.3 Баданга хүдэр 20
- 1.4 Идлэг шонхор 24
- 1.5 Хээрийн бүргэд 28
- 1.6 Цоохор ирвэс 30
- 1.7 Бөхөн 32

2 ХҮН БА БАЙГАЛЬ 35

- 2.1 Байгаль хамгаалах иргэдийн оролцоо ба хамтын хүч 36
- 2.2 Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ 39
- 2.4 **Ярилцлага:** Зэрлэг амьтны тоо толгой 30% орчим өссөн 44
- 2.5 Элсэн далайн хөлөг онгоцоо аварья 50
- 2.6 **Ярилцлага:** Зэрлэг амьтан, малын бэлчээр давхцаж байна 52

3 ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДАА 53

- 3.1 Зэрлэг амьтад аврал эрж байна 54
- 3.2 **Ярилцлага:** Нохой бол үнэрлэх мэдрэмж сайтай амьд үнэрийн аппарат 58
- 3.3 **Ярилцлага:** Амилж босоод онгон байгальдаа эргэн очоосой гэж боддог 62

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

- Тэмээний гарал үүсэл **14**
- Тарваганы экосистемд гүйцэтгэх үүрэг **18**
- Хүдрийн заар **22**
- Идлэг шонхор нь үлийн цагаан оготно бүхий нутагт элбэг тохиолдоно **26**
- Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал **38**
- Амьд байгалиа хамгаалж, эдийн засгаа сэргээсэн шилдэг туршлага **48**

Энэхүү тайланг МӨР төслийн багтай хамтран бэлтгэв.



Амьд байгалийн тухай мэдлэгийг түгээж боловсролыг дэмжинэ.



FB/ProjectMur

Эмхтгэж, эхийг бэлдсэн:

- Д. Баянмөнх
- Б. Юмчин,
- О. Соронзонболд,
- Р. Мөнхбат.

Редактор:

- Г. Байгаль,
- У. Тунгалаг,
- Ш. Мягмарсүрэн,
- Ц. Мөнхзул,
- Г. Эрдэнэцолмон,
- Б. Мөнхжаргал.

Гэрэл зургийг:

- ЛАСН-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар,
- МӨР гэрэл зургийн сан,
- ГЕГ-ын Эрэлч нохойн сургалтын төв,
- С. Гомбобаатар,
- Э. Идэрбат,
- М. Ууганбаяр.

Уг бүтээлийг ЛАСН болон МӨР төслийн зохиогчийн эрхээр хамгаалсан бөгөөд зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН)-ийн хамт олон бид 2018-2021 онд Монгол Улсын байгаль, зэрлэг

амьтан хамгаалах, монголчуудын энэ талын мэдлэг мэдээллийг сайжруулах чиглэлээр хийж бүтээсэн зүйлс, ололт амжилтаа зорилго нэгт нөхөдтэйгээ ийнхүү хуваалцаж байгаадаа баяртай байна.

ЛАСН нь Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)-ын Засгийн газрын Зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах сорилын сан (Illegal Wildlife Trade Challenge Fund), Дарвины санаачилга сан (Darwin Initiative), АНУ-ын Үндэсний газарзүйн нийгэмлэг (National Geographic), Гаяа амьтны хүрээлэн (Gaia Zoo), Эволюцын өвөрцөг, устаж байгаа зүйлийг хамгаалах сан (EDGE foundation), Английн хавтгай хамгаалах сан (Wild Camel Protection Foundation), Шинэ Зеландын Бээжин дэх Элчин сайдын яамны өгөөмөр тусламж дэмжлэгээр энд тайлагнаж буй үр дүнд хүрч чадсан билээ. Иймд эх орны маань үзэсгэлэнт байгалийг хамгаалах сайхан үйлсэд чин сэтгэлийн дэмжлэг үзүүлсэн санхүүжүүлэгчдэдээ үр шимийг хүртсэн монголчуудынхаа өмнөөс гүн талархал илэрхийлье.

Бидний үйл хэрэгт тууштай хамтран зүтгэж тулгарсан сорилтыг хамтдаа туулж, амжилттай ажиллахад найдвартай түшиг тулгуур болж байдаг ИБУИНВУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Филип Малони, тус яамны ажилтан А. Солонго, МУИС-ийн профессор, ЛАСН-ийн зөвлөх С. Гомбобаатар, ЛАСН-ын хөтөлбөрийн анхны зохицуулагч асан Натан Конабой, ЛАСН-ийн ажилтан асан М. Мөнхжаргал, Байгаль орчин аялал жуулчлалын яамны ахлах ажилтан, Нүүдлийн зүйлийг хамгаалах конвенцын үндэсний зохицуулагч Д. Ариунтуяа, ГИДЦГ-ын Хамгаалалтын захиргааны дарга Ч. Баярбат,

Архангай аймгийн Байгаль орчин аялал, жуулчлалын газрын дарга асан Н. Баянмөнх, ГЕГ-ын Эрэлч нохойн сургалтын төвийн захирал

Б. Наранбадрах нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлж, бүтээх их үйлсэд нь амжилт хүсье.

ЛАСН-ийн Монгол орон дахь нэрийн хуудас болсон зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулахад үндэсний чадавх буй болгох, ялангуяа, эрэлч нохойн албыг дэмжих ажил, нутгийн иргэдэд түшиглэсэн Орон нутгийн тусгай

хамгаалалттай газрын менежментийн загвар буй болгох ажил, манай улсад цөөхөн үлдээд буй хавтгай тэмээг судлах, хамгаалах ажлуудыг алсын хараа удирдлагаар хангаж, захиргаа ложистикийн найдвартай ар тал болдог ЛАСН-ийн Лондон дах Төв газрын ажилтнуудын дэмжлэг, зөвлөмж үнэлж баршгүй ач холбогдолтой байсныг онцолж байна. Үүнд, ЛАСН-ийн Азийн хөтөлбөрийн дарга Моника Робел, мөн дарга асан Гитанжали Бачатаряа, Монгол дахь хөтөлбөрийн зохицуулагч асан Самуэл Мерсон, санхүүгийн ажилтан асан Александра Доналдсон нарын зүрх сэтгэл, мэргэжлийн ур чадвар бидний ажилд шингэсэн юм.

Эцэст нь эдгээр ололтыг өөрсдийн хөлс хөдөлмөр чин сэтгэлийн хүчин чармайлтаар буй болгосон хамт олондоо баяр хүргэж энэхүү өмнөх үгээ өндөрлөхийн ялдамд манай тайланг олон нийтийн хүртээл болгоход хамтран ажилласан МӨР-ийн залуустаа талархаж ажлын амжилт хүсье.



У. ТУНГАЛАГ

ЛАСН-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын
Захирал

ЛОНДОНГИЙН АМЬТАН СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГ

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг (ЛАСН) нь 200 шахам жилийн түүхтэй, зэрлэг амьтан судлах, хамгаалах үйл ажиллагаа явуулдаг дэлхийн ууган байгууллагын нэг юм. ЛАСН-ийн үндсэн зорилго бол зэрлэг амьтад, тэдгээрийн идээшил нутгийг хамгаалах, устаж үгүй болохоос сэргийлэх үйлсийг дэмжих, ард иргэдийг шинжлэх ухаанч мэдээллээр хангахад оршдог. ЛАСН дэлхийд алдартай Лондон болон Випснэйдийн амьтны хүрээлэнтэй хамтарч ажиллахаас гадна 50 гаруй улс оронд зэрлэг амьтан хамгаалах ажил гүйцэтгэдэг.

ЛАСН нь 2003 оноос Монгол Улсын их сургуультай хамтран зэрлэг амьтан хамгаалах, судлах “Тал нутгийн түүчээ” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үйл ажиллагаагаа эхэлсэн.

ЛАСН-ээс Монгол Улсад хэрэгжүүлсэн томоохон ажил бол Байгаль Хамгаалах Олон Улсын Холбоо (БХОУХ)-ны Улаан дансны шалгуураар зэрлэг амьтан, ургамлын хамгааллын статусыг үнэлж, хөхтөн амьтан, шувуу, загас, хоёр нутагтан болон ургамлын Улаан дансыг боловсруулан гаргасны үндсэн дээр Ховордож буй зүйлүүдийг хамгаалах төлөвлөгөөг эмхэтгэв. Ингэснээр нугаламт амьтдаа БХОУХ-ны ангиллаар үнэлсэн Азийн анхны улс болсон. Түүнчлэн зэрлэг амьтдын экологи, шилжилт хөдөлгөөнийг судлахаар Монгол орны зарим тусгай хамгаалалттай газарт автомат камерын мониторинг хийж, Зэрлэг амьтны зурган индексийг гаргасан. Монголын залуу биологичдыг чадавхжуулах олон улсын оюутны зуны сургалтыг зохион байгуулж, ЛАСН-ээс зарладаг Эволюцын өвөрмөц, устаж байгаа зүйл (EDGE Program)-ийг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд залуу судлаачдыг тэтгэлэгт хамруулав. 2018 оноос хэрэгжүүлсэн дараах гурван төслийн тайланг ийнхүү толилуулж байна.

2026 онд тэмдэглэх 200 жилийн ойг угтсан “ЛАСН– 200” стратегийн зорилтын дагуу дараах тэргүүлэх гурван чиглэлээр ажиллаж байна. Үүнд:



Хүн ба байгаль: Хүн төрөлхтөн ба зэрлэг амьтны зохистой харилцан холбоог бэхжүүлнэ. Зэрлэг амьтан амар тайван амьдарч буй газарт л хүний хөгжил тогтвортой байж чаддаг.



Зэрлэг амьтны эрүүл мэнд: Зэрлэг амьтан эрүүл энх бол хүн, түүний амьдарч буй орчин эрүүл байна. Халдварт өвчин гэдэг хэлж ирэхгүй, хийсч ирдэг билээ.



Мөхөж буй зэрлэг амьтдыг авран хамгаалах: Бүх төвшүнд байгаль хамгааллын бодлогыг сайжруулж, шинжлэх ухаанд суурилсан хамгаалах арга замыг тодорхойлж, нэвтрүүлэх нь чухал.

Хавтгай тэмээ, түүний идээшил нутгийг хамгаалах төсөл

Хавтгай тэмээний сүүлчийн популяцийг тэтгэгч Говийн их дархан цаазат газар (ГИДЦГ)-ын “А” хэсэгт урт хугацааны судалгаа, мониторинг хийж, Хамгаалалтын захиргаа, Орчны бүсийн таван сум, Хил хамгаалах ангиудтай хамтран хавтгайн идээшил нутгийг хамгаалах замаар тоо толгойг барих, улмаар өсгөх зорилготой. ЛАСН 2012 онд Монгол Улсын хавтгай тэмээ хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, 2014 онд хавтгайн тооллого хийж 500 бодгаль хүрч буурсныг тогтоосон. Автомат камер ашиглан хавтгайн нүүдэл, экологи, уст цэгийн судалгааг 2019 оноос эхлэн өргөн хүрээнд хийж байна. Мөн ГИДЦГ-ын Орчны бүсийн менежментийг ландшафтын түвшинд гүйцэтгэх институцийн чадавх бий болгохын тулд талуудтай хамтран ГИДЦГ-ын Хамтын менежментийн зөвлөл байгуулж, Зөвлөлийн журам, Хавтгай хамгаалах үйл ажиллагааны эхний төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг дүгнэж байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал ба ОНТХГ-ын загвар менежмент буй болгох төсөл

Архангай аймгийн Булган суманд орших Хойд Могойн гол-Тээлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ)-ын ховор ургамал, амьтад, тэдгээрийн амьдрах орчин болох Хангайн бүсийн ойн сан, бэлчээрийн экосистемийг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах, улмаар ОНТХГ-ын загвар менежмент буй болгох зорилготой. Дэлхийд ихээхэн тархаж буй нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын үзэл санааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ БХОУХ-ны тусгай хамгаалалттай газар нутгийн V ба VI ангилалд дүйцэх ОНТХГ-ын менежментийн зорилго, шинж чанар, засаглалын зарчим, засаглалд оролцогч талуудын эрх үүрэг хариуцлага, менежмент явуулах институцийн тогтолцоо арга хэрэгслийг тодорхойлоход хувь нэмрээ оруулж буй төсөл юм.

Зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах, таслан зогсоох төсөл

Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдааны өнөөгийн байдал, хууль эрх зүй, институцийн орчин, бодлогын хэрэгжилтэд гарч буй орхигдол, анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор “Зэлүүд тал-2: Монгол Улс дахь зэрлэг амьтны хууль бус худалдааны хямралт байдал” хэмээх томоохон судалгаа хийж, үр дүнг олон нийт, холбогдох талуудад танилцуулсан. Энэхүү судалгааны зөвлөмжийн дагуу ЛАСН энэхүү төслийг ИБУИНВУ-ын Засгийн газрын санхүүжилттэй хэрэгжүүлэн дүгнэж байна. Тус төсөл олон улсын хамтын хүчин чармайлтаар тэмцэх шаардлагатай болоод байгаа зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулахад Монголын Гаалийн байгууллагын энэ төрлийн зөрчлийг илрүүлэх чадавхыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа хандууллаа. Ялангуяа, ГЕГ-ын эрэлч нохойн сургалтын арга зүй, орчин, тоног хэрэгслийг сайжруулах, нохойтой байцаагчдын ур чадварыг дээшлүүлэхэд ИБУИНВУ-ын

Хилийн албаны мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж эрэлч нохойн албаны үйл ажиллагааг дэлхийн жишигт ойртуулах алхмыг хийсэн төсөл юм. Зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэж буй Монгол Улсын хүчин чармайлтыг ЛАСН-ийн хүсэлтээр олон улсын нэр хүндтэй Финансиал Таймс сонин сурвалжилж дэлхий нийтэд мэдээлсний ачаар үнэрч нохойн албыг үргэлжлүүлэн дэмжих эхний санхүүжилтийг аваад байна. Нохойтой ажилладаг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын зэрлэг амьтны хууль бус худалдаатай тэмцэхэд оруулж буй хувь нэмрийг зохих ёсоор үнэлүүлэхээр ЛАСН-ийн нэрэмжит “Зэрлэг амьтныг хамгаалагч” шагналыг буй болгосон бөгөөд уг өргөмжлөлийг 2,000 фунт стерлингийн мөнгөн шагнал дагалддаг.

ЗОРИЛТОТ ЗҮЙЛ

ЛАСН-ийн үйл ажиллагааны эхний чиглэл бол мөхлийн ирмэгт тулсан биологийн зүйлийг судалж, хамгааллын оновчтой менежментийг тодорхойлох юм. Тайлангийн эхний бүлэгт ЛАСН-ийн Монгол Улс дахь зорилтот зүйлийн амьтдыг танилцуулна. Манай байгууллагын гол зорилтот зүйл нь олон улсын түвшинд судалгаа, хамгааллын чухал ач холбогдолтой хавтгай, монгол тарвага, баданга хүдэр, идлэг шонхор, хээрийн бүргэд зэрэг ховор зүйлүүд юм. Түүнчлэн, хууль бус худалдаанд өртөмтгий цоохор ирвэс, бөхөн хамгааллын тэргүүн эгнээнд багтдаг.



ХАВТГАЙ

Camelus ferus



Дэлхий дээрх сүүлчийн зэрлэг тэмээ болох хавтгай нь Монголын ГИДЦГ-ын “А” хэсэг, Хятадын Лоб нуур, Гашуун говьд нийт 1,000 хүрэхгүй бодгаль үлдсэн.

Дэлхий дахинд устах аюул нүүрлэсэн энэхүү зүйлийг гүнзгий судалж, хамгааллын оновчтой менежмент хэрэгжүүлэхийн төлөө ЛАСН нь оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр говь цөлийн задгай ус хатаж, ширгэх үзэгдэл нэмэгдэж, хавтгай төдийгүй бусад зэрлэг амьтанд том сорилт тулгараад байна.

ХАВТГАЙ ХАМГААЛАЛ

МОНГОЛ

ТОО ТОЛГОЙН ӨӨРЧЛӨЛТ




УСНЫ ХОМСДОЛ БА ЧАНАРЫН СУДАЛГАА

ГИДЦГ-ын зэрлэг амьтны ундны гол эх үүсвэр болсон булаг шандны усны чанар хэвийн ч уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан жил ирэх тусам ширгэж байна.

ГИДЦГ-ын хавтгай болон бусад зэрлэг амьтан хамгийн түгээмэл умдаалдаг найман булаг шандыг сонгон, хууль бус уул уурхай, хүний хүчин зүйлээс үүдэлтэй бохирдол, нөлөөллийг тодруулах дүн шинжилгээ хийж үзэхэд сорьцод усаар дамжин халдварладаг ямар нэг өвчин эмгэг үүсгэгч нян илрээгүй, усанд агуулагдах бодисын хэмжээ хэвийн, амьтад уухад тохиромжтойг хоёр жил гүйцэтгэсэн усны биохими болон нянгийн судалгаагаар тогтоов.

Хавтгайн амьдрах орчинг сайжруулж, нүүдлийн зам дахь усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор цооног сэргээж, хөв байгуулахын тулд гидрологийн өрөмдлөг хийсэн 80-130 метрийн гүнтэй Гантөмөрийн сайр, Чонын довон, Буурын хяр, Нарийн хөх хоолой, Зүүн шарга, Шар хулс, Хатан суудал зэрэг 2018 онд БОАЖЯ-ны захиалгаар гаргасан зургаан



УСАЛГААНЫ БАЙГУУЛАМЖ
баригдсанаар говийн зэрлэг амьтны усны эх үүсвэр нэмэгдэхээс гадна, ойроос сөрөг нөлөөгүй ажиглан судлах боломж бүрдэнэ.

цооногоос хавтгайн нүүдлийн замд хамгийн тохиромжтой Гантөмөрийн сайрын цооногийг сэргээн мэдрэгч бүхий нарны өргүүрт худаг гаргаж, хөв байгуулав. Гантөмөрийн сайрыг дараах шалгуурыг харгалзан сонгов. Үүнд:

1. Олон зүйлийн амьтан умдаалах боломжтой,
2. Ойр орчимд усны эх үүсвэр байхгүй,
3. Хавтгайн нүүдлийн зам дагуу оршдог,
4. Усны нөөц сайтай,
5. Мал болон хилийн бүсээс зайдуу,
6. Байгаль хамгаалагчдын ундны усны хэрэгцээнд нийцсэн,
7. Газрын гадаргын хувьд бүтээн байгуулалтад тохиромжтой, үер усны эрсдэлгүй зэргийг харгалзав.



Орчны бүсийн малчдад хавтгайн тухай мэдлэг түгээв.

ХҮНИЙ НӨЛӨӨ БА БЭЛЧЭЭРИЙН ДАВХЦАЛ

ГИДЦГ-ын зарим хэсэгт уст цэгээс хамаарч зэрлэг амьтан болон малын бэлчээр давхцаж байна. Бэлчээрийн нөхцөл хүндэрсэн улмаас орчны бүсээс дотогш нутаглах малчин цөөнгүй.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас булаг шанд ширгэж байгаа нь мал болон зэрлэг амьтны бэлчээр давхцах нөхцөлийг бүрдүүлж байна. Түүнчлэн хууль бус гар аргаар алт олборлогч буюу “нинжа” нарын тоо нэмэгдэж буй нь хүний нөлөөллийн өөр нэгэн хэлбэр юм.

ЛАСН нь ГИДЦГ-ын орчны бүсэд хамаарах Говь-Алтай аймгийн Алтай, Цогт, Эрдэнэ, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст суманд хавтгайн талаарх иргэдийн мэдлэгийг тандан судлах, бэлчээрийн давхцалын зэрэглэлийг тогтоох ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд нутгийн иргэдийн байгаль хамгааллын мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрэв. Энэ хүрээнд ГИДЦГ-ын мэргэжилтэн, байгаль хамгаалагч, хилийн цэргийн хоёр отрядын албан хаагчдад зориулсан сургалт, орчны бүсийн иргэдтэй уулзсан уулзалт, аман асуулга зэргээр дамжуулан 580 орчим хүнд хавтгайн тухай мэдлэг мэдээлэл хүргэв. Сургалтын зорилго нь иргэдийн байгаль хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлж, зэрлэг амьтны талаар зөв мэдээллээр хангах, улмаар байгаль хамгаалалд татан оролцуулж, хавтгайд тулгарч буй хүний

нөлөөллийг бууруулах, автомат камерын урт хугацааны судалгааны талаар мэдлэг мэдээллээр хангах байлаа.

Мөн говийн биологийн олон янз байдал, нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох оновчтой менежментийг тодорхойлох ажлыг эхлүүлж, талуудын уулзалтыг хоёр удаа зохион байгуулжээ. Үүний үр дүнд орчны бүсийн Хамтын менежментийн зөвлөлийг анх удаа байгуулж, хавтгай хамгаалах хамтын менежментийн төлөвлөгөөг хамтран боловсруулж, 2019 оны тавдугаар сард батлав. Уг төлөвлөгөөний үндсэн зорилго нь говийн экосистем дэх хавтгай болон бусад зэрлэг амьтныг хамгаалж, тоо толгойг нь нэмэгдүүлэхийн сацуу амьдрах орчинг хамгаалах, тэтгэх юм. Энэ хүрээнд тавьж буй зарим зорилтыг онцолбол:

- Бэлчээрийг зүй зохистой, хариуцлагатай ашиглах журмыг мөрдүүлэх,
- Эдрэнгийн нуруу орчмын бэлчээрийн давхцалыг арилгаж ДЦГ-ын горим дэглэмийг мөрдүүлэх,
- Хууль бус агнуурын эсрэг эргүүл тогтмол гаргаж, хяналтыг чангатгах,
- Эрлийз тэмээ уралдаанд оролцуулахыг орчны бүсийн бүх суманд хориглох зэрэг орно.



580
иргэн байгаль хамгааллын мэдлэгээ тэлсэн.



АВТОМАТ КАМЕРЫН СУДАЛГАА




ГИДЦГ дахь хавтгайн шүтэн байршдаг цөм нутагт хаврын улиралд гэрийн тэмээ, адуу бэлчээрлэж байгаа нь цаашид хамгааллын төлөвлөгөөнд анхаарах асуудлын нэг болж байна.

Бид 2018 оноос эхлэн хавтгайн тархац, байршил, тоо толгой, хил дамнасан шилжилт хөдөлгөөнийг тогтоох зорилгод нийцүүлэн ГИДЦГ-т санамсаргүй сонгосон талбайд 170, улсын хил орчимд 80, зорилтот дөрвөн уст цэгт 25-30 ширхэг хөдөлгөөн мэдрэгч бүхий автомат камер суурилуулан, зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнийг тандах урт хугацааны судалгаа гүйцэтгэж байна. Эдгээрээс санамсаргүй сонгосон талбайн судалгааг 2019 оноос Английн Хавтгай хамгаалах сантай хамтран хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хоёр сая орчим гэрэл зураг цуглуулж шүүн боловсруулав. Уг ажлын хүрээнд хоёр магистрын сэдэвт ажлыг хамгаалж, нэг докторын сэдэвт ажлын судалгааг үргэлжлүүлж байна.

ГИДЦГ-ын “А” хэсэгт байрлах зорилтот дөрвөн уст цэгт бүтэн жилийн турш автомат камер байршуулан судлахад 28,113 зураг авсан бөгөөд эдгээрийн 3,560 нь Баруун тооройд, 11,261 нь Баруун шаргад, 5,985 нь Майхан булагт, 7,307 нь Нүдэн булагт тус тус авагджээ. Зургаар нийт 19 зүйлийн амьтныг тодорхойлсон бол үүний 12 нь хөхтөн амьтад байв. Уст цэг тус бүрт ирж буй хөхтөн амьтны олон янз байдал нэлээд ялгаатай байлаа. Баруун тооройд хөхтөн амьтны олон янз байдал хамгийн их байсан бол Баруун шаргад хамгийн бага байв. Хамгийн их тохиолдоцтой зүйлд хавтгай, саарал чоно, хулан, хар сүүлт, бор туулай, аргаль, мазаалай, гэрийн адуу гэсэн найман зүйл бүртгэгснээс тохиолдцын 30 хувийг хавтгай эзэлж байна.


МОНГОЛ ДАХЬ АВТОМАТ КАМЕРЫН ХАМГИЙН ДАЛАЙЦТАЙ СУДАЛГАА

Камер байршуулах цэгийг доорх газрын зурагт үзүүлсний дагуу санамсаргүй байдлаар сонгож ГИДЦГ-ын нутаг дэвсгэрийг бүрэн хамруулан камеруудыг суурилуулав. Ингэж байршуулах нь ховор амьтдын байршил, тоо толгойг тогтоох чухал аргагүй бөгөөд Монгол оронд ийм өргөн хүрээнд ашигласан анхны тохиолдол гэж үзэж болно. Автомат камер (Camera trap) нь амьтны гэрэл зураг, дүрс бичлэгийг ямар нэгэн гаднын нөлөөгүй хальсанд буулгах чухал хэрэгсэл юм. 1990-ээд оноос эхлэн ховор амьтныг илрүүлэх, тоо толгой болон зүйлийн баялгийг тодруулж үнэлэх, тэдгээрийн амьдрах орчны ашиглалт зэргийг судлах зорилгоор өргөн хэрэглээнд оржээ.



Уст цэг дээр ирэх давтамж:

Хавтгай болон чонон уст цэг дээр ирэх давтамж 12-р сард илүү давхцаж байна. Харин гэрийн адуу хаврын улиралд хавтгайн нутагт ирэх давтамж өндөр байгааг цаашид анхаарах шаардлагатай.



Хулан (*Equus hemionus*)
Унагаа дагуулсан гүүнүүд




Хар сүүлт зээр
(*Gazella subgutturosa*)
Ихэр янзага дагуулсан шаргачин



Хавтгай
(*Camelus ferus*)
Ботгоо дагуулсан ингэ

2

ГИДЦГ-ын
зэрлэг амьтны
хоёр сая орчим
зураг цуглуулж,
боловсруулав.



ГОВИЙН АМЬТАД
НЬ ЭКОСИСТЕМИЙН
ҮНЭТЭЙ БҮРЭЛДЭХҮҮН
ХЭСЭГ

Люси Хантли, Лондонгийн их сургуулийн магистр

ЛАСН-ийн дэмжлэгээр говийн хөхтөн амьтны судалгааны материалыг боловсруулан магистр хамгаалсандаа баяртай байна. ГИДЦГ-ын зүйлүүд өөр өөр уст цэгийг шүтэх хандлагатай байв. Тухайлбал, мазаалай, аргаль, чоно зэрэг амьтад өвс ургамлаар баялаг Баруун тооройд, харин хавтгай Баруун шаргад ус уух хандлага ажиглагдсан. Баруун шаргын ус бусад уст цэгээс илүү шорвог учраас хавтгай умдаалах дуртай байж болох юм. ГИДЦГ-ын ойролцоо нутагладаг айлуудын тэмээний тоо толгой өссөнөөс хавтгайд халдварт өвчин дамжуулах, эрлийзжих эрсдэл өндөр байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж цаг агаар тогтворгүй болж, хавтгай ус, идэш тэжээлийн хомсдолд орж байна. Говийн зэрлэг амьтад нь экосистемийн үнэтэй бүрэлдэхүүн хэсэг учраас зайлшгүй хамгаалах ёстой. Ялангуяа, тодорхой зүйлийн амьтад дэлхийн хэмжээнд устаж буй ангилалд орсон байдаг тул байгальд нь хамгаалах, өсгөх бодлогыг нэн тэргүүнд тавих хэрэгтэй. ЛАСН-ийн Монгол дахь багийн ховор амьтдын төлөө хийж буй ажлаар бахархаж байна. Ялангуяа, хамгааллын ажилд нутгийн иргэдийг татан оролцуулан урт хугацааны менежментийг хэрэгжүүлж байгаа нь гайхалтай.



Алтайн аргаль
(*Ovis ammon ammon*)



Буурал шилүүс
(*Lynx lynx*)



Мазаалай
(*Ursus arctos gobiensis*)
Залуу мазаалай



Мазаалай
(*Ursus arctos gobiensis*)
Бие гүйцсэн мазаалайн
тавхай тод харагдаж
байна.

Саарал чоно
(*Canis lupus*)
Цатгалан төрх




Саарал чоно
(*Canis lupus*)
Гуринхайтсан төрх



ТЭМЭЭНИЙ ГАРАЛ ҮҮСЭЛ

Бидний мэдэх хоёр бөхт тэмээний өвөг зургаан сая жилийн өмнө, одоогийн Хойд Америкийг Ази тивтэй холбож байсан Берингийн хоолойгоор давж Азид тархжээ. Тэр үед Ази тив их хүйтэн байсан учраас хүнсний нөөцөө хадгалахын тулд хоёр бөхтэй болсон гэж үздэг.



Сахарын цөл, Африк, Ойрх Дорнодод байдаг дромидар буюу нэг бөхт тэмээ нь хоёр бөхт тэмээнээс үүсэлтэй гэж үздэг. Учир нь, түүний долоон хоногтой үр хөврөлд хоёр бөх илэрдэг. Энэ нь өвгийн шинж тэмдэг үр хөврөлд давтагддаг гэх Эрнст Хекелийн Биогенетикийн хуулийн нэгэн жишээ юм.

Гурван сая жилийн тэртээ Өмнөд Америк руу тархсан өвгөөс лам гөрөөс, алпакас, куанакос, викунас зэрэг амьтад үүссэн.

36%

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т иргэдтэй хамтарсан гурван жилийн судалгаа, хамгааллын ажлын үр дүнд тарваганы тоо толгой 36 хувиар өссөн.

МОНГОЛ ТАРВАГА

Marmota sibirica

Экосистемийн инженер, идэш тэжээлийн хэлхээний чухал бүрэлдэхүүн тарваганы тоо толгой Монгол оронд XX зууны дунд үед 17-23 сая байсан бол эдүгээ даруй 3-4 дахин буурсан.

Манай оронд Алтайн болон Монгол хэмээх хоёр зүйлийн тарвага бий. Ойт хээр, уулын хээр, тал хээрийн бүсэд өргөн тархсан тарвага нь газрын өнгөн давхрааг сийрэгжүүлэн хольж хөрсний бүрдэл бүтцийг сайжруулж, ургамлын нөмрөгт эерэг нөлөөг үзүүлдэг төдийгүй мах идэшт хөхтөн амьтад, шувуудын гөрөөл болдог ач холбогдолтой. Өвсөн тэжээлт энэ мэрэгч нь идэвх хөдөлгөөний ид үедээ ч мал, зэрлэг амьтны бэлчээрийн өвс ургамлыг булаах, хороох сөрөг нөлөөгүй.


Манай улсад хамгийн их авладаг амьтан бол тарвага. Арьсыг нь худалдах, махыг нь хүнсэнд хэрэглэх зорилгоор бүлийн үржил, нөхөн төлжилтийг үл тоон зохицуулалтгүй агнасны улмаас бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” хэмээх ангилалд ороход хүргэжээ. Монголчуудын уламжлалт уургийн эх үүсвэр, эмчилгээ, арьс үсний хэрэгцээ болдог бөгөөд жил тутмын тарваганы арьсны худалдаа 1800-аад оноос хойш дунджаар 1.2 саяд хүрч байжээ. “Зэлүүд тал II” тайланд дурдсанаар Монгол Улсад зөвхөн 2015 онд 850

мянга орчим тарвагыг авласан байна.

Тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь цөөрсөөр байгаа учраас хууль бус худалдааг таслан зогсоохын тулд ЛАСН оролцогч талуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, ГЕГ-ын Нохойн сургалтын төвтэй хамтран улсын хилээр тарваганы арьс гаргах оролдлогыг илрүүлэх аргачлалыг сайжруулах зорилгоор Их Британи, Умард Ирландын Хилийн Албатай нэгдсэн сургалт болон туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулав.

Түүнчлэн тарваганд тулгарч буй гол асуудал болох хэт агнуурыг хязгаарлахын тулд ЛАСН-ээс Архангай аймгийн Булган суманд хэрэгжүүлж буй ОНТХГ-т тарвага нутагшуулах төслийн хүрээнд нутгийн иргэдэд холбогдох мэдээлэл өгч, тарвага хамгааллын ажлыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 10 нөхөрлөлийн идэвхтэн байгаль хамгаалагч нар байнгын эргүүл хийж, сар бүр тарваганы тоо толгойг тогтоож, хууль бус агнуурт хяналт тавьдаг болсон.

850,000
орчим тарвагыг 2015
онд Монгол улсад
агнажээ.



ХАРАГДДАГҮЙ
БАЙСАН
ТАРВАГАНЫ
ТОО ӨССӨН

**Б. БАТДОРЖ, Байгаль
орчны хяналтын улсын
байцаагч**

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш хулгайн ан үгүй болж, манай нутагт төдийлөн харагддаггүй болсон тарвага хүртэл өсөж байгаад маш их баярладаг.



Монгол тарвага манай орны уулын хээрт зонхилж тохиолдоно.

ОЛОН УЛС
АНХААРАЛД
ӨРТӨХӨӨРГҮЙ
LC

ХОВОРДОЖ
БОЛЗОШГҮЙ
NT

ЭМЗЭГ
VU

МОНГОЛ
УСТАЖ
БОЛЗОШГҮЙ
EN

УСТАЖ БАЙГАА
CR

БАЙГАЛЬД
УСТСАН
EW

УСТСАН
EX



II ХАВСТРАЛТ

I ХАВСПРАЛТ

85%

Амьдралынхаа
85 хувийг нүхэнд
өнгөрүүлдэг.

10

Байгальд 10 орчим
жил амьдарна.

25
САЯ ЖИЛ

Тарваганы өвөг 25
сая жилийн өмнө
амьдарч байжээ.



Нагай дунджаар
5-7, зарим тохиолдолд 12
мөндөл төрүүлдэг.



Монголын хээрийн
экосистемд тарвага
инженерийн үүрэг
гүйцэтгэнэ.



БУРХИ



ТАРЧ



МӨНДӨЛ



Биеийн урт **47-58 см**

Сүүлний урт **9-16 см**

Биеийн жин **8-10 кг**




ТАРВАГАНЫ ЭКОСИСТЕМД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ



МУУ НҮХ



ЗУСААЛ НҮХ



ИЧЭЭ НҮХ


Монгол тарвага хээрийн экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд зэрэгцэн орших амьд биет болон амьгүй байгальтай шууд болон дам хамааралтай шүтэлцэн амьдрах нарийн зүй тогтолтой. Монгол тарвага бусад мэргэчийн адил хөрсийг сийрэгжүүлж, чийг, агаарын солилцоог эрчимжүүлэн, эрдэс, шим бодисоор баяжуулдаг. Тарвага нь чоно, бүргэд зэрэг нэгдүгээр зэргийн махчнаас гадна мануул, үнэг, хярс зэрэг бусад махчны гөрөөл болж идэш тэжээлийн хэлхээнд оролцдог.

Түүнээс гадна тарваганы ухсан нүх олон амьтны хоргодох, үр төлөө өсгөн бойжуулах орон байр болдог. Тарваганы дош гурван төрлийн нүхтэй, эдгээр нь тус тусын үүрэгтэй. Муу нүх нь гэнэтийн аюул тохиолдох мөчид түр хоргодох зориулалттай, харьцангуй энгийн бүтэцтэй, ноохойн тогоогүй, ихэвчлэн нэг амтай,

нүхний амсар нь дунджаар 1.5-7 м, хөрсний 1 м орчим гүнд байрлана.

Харин эзэмшил нутгаа бүрэн ашиглах, гарч идээшлэх, махчин амьтдаас биеэ хамгаалах зориулалттай түр орогноход тохиромжтой олон амтай нүхийг зусаал нүх гэнэ.

Ичээ нүх 1-3 м орчим хөрсний гүнд 0.2-1.2 м³ багтаамжтай, нэг ба хэд хэдэн ноохойн тогоотой, хэдэн арван метр урттай хонгил нүхнээс бүтнэ. Ичээ нүхний амсраас 0.5-2.1 м хол зайд баруун, зүүн тийш салсан 0.6-2.3 м урт, хавар ичээнээс гарснаас хойш ичих хүртлээ ялгадсаа хураадаг мухар нүх буюу баасны өхтөө бий. Тарвага ичээлэхэд бэлтгэн нүхэндээ 2.3-5.2 кг хуурай өвс зөөж хураана. Үүнийг ноохой гэх ба идэш тэжээлд хэрэглэхгүй харин дулаалга маягаар ашиглана.



О

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т иргэдтэй хамтарсан гурван жилийн судалгаа, хамгааллын ажлын үр дүнд нэг ч хүдэр агнаагүй.

БАДАНГА ХҮДЭР

Moschus moschiferus

Баданга хүдэр бол Монгол Улсад нэн ховор амьтан бөгөөд 1970 оноос хойш тоо толгой нь 90 гаруй хувиар буурчээ.

Хүдэр нь Монгол, ОХУ, БНХАУ, Солонгосын хойг зэрэг цөөхөн нутагт тархсан. Монгол орны Хэнтий, Хөвсгөл, Хангайн уулархаг нутагт тохиолдоно. Ялангуяа, Хөвсгөл, Хангайн уулсад тархан байршихад тохиромжтой учраас манай орны хүдрийн нөөцийн 83 хувь бий. Далайн төвшнөөс дээш 1,700-2,300 м өндөрт хуш, шинэсэн ойд сүүдэрлэг хэц, хажуугийн хөвдөн дэвсгэртэй хөрс, модны хаг ихтэй балар шигүү ойд байршина.



Монгол Улс 1959 онд хүдэр агнахыг хориглосон. Хүдэр ховордсон үндсэн шалтгаан нь хууль бус агнуур юм. Гирээний заарыг авахын тулд 1990—2001 оны хооронд бие гүйцсэн 25,000 гирээг хууль бус болон зөвшөөрлийн дагуу агнасан болохыг Монгол Улсын хөхтөн амьтны улаан дансанд тэмдэглэжээ. Монгол Улсын хэмжээнд 1970 онд 80,000, 1986 онд 44,000 тоо толгойтой байсан хүдрийг хамгийн сүүлд 2010 оны байдлаар 6,500-аас бага гэж үнэлжээ.

Мөн “Зэлүүд тал II” тайланд 1996—2015 оны хооронд 309 хүдрийг Монгол Улсын хилээр гаргасан тухай дурдсан байна.

Ингэж олон тоогоор авлах нь удаан өсөлттэй хүдрийг мөхөл рүү шууд хөтлөх болжээ. Учир нь гирэгчин зургаан сар хээлээ тээсний эцэст жилд ганц удаа төллөхдөө ихэвчлэн нэг шовшоорой гаргана. Дунджаар 650—700 гр жинтэй төрөх шовшоорой төрсөн газраа тав хоног хөдөлгөөнгүй

хэвтдэг учраас чоно, бүргэд, шилүүс зэрэг махчин амьтны гөрөөл болох эрсдэл өндөр тул тэдний тоо толгой өсөхгүй, буурах хандлагатай байдаг.

Хүдэр нь ойд амьдардаг махчин амьтад болох чоно, шилүүс, нохой зээхийн идэш тэжээл болдог учраас ойн экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Ойн хамгийн сонор амьтан учир аюулыг урьдаас мэдэж шүгэлдэх мэт чимээ гаргахад бусад амьтан сэрэмж авдаг байна.



АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ	ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ	ОЛОН УЛС ЭМЗЭГ	МОНГОЛ УСТАЖ БОЛЗОШГҮЙ	УСТАЖ БАЙГАА	БАЙГАЛЬД УСТСАН	УСТСАН
LC	NT	VU	EN	CR	EW	EX



ЛАСН-ийн алсын хараа нь амьд байгалийн эрүүл мэнд, хүн байгалийн харилцан шүтэлцээ дээр тогтдог. Тиймээс хүдэрт нөлөөлж буй гол хүчин зүйл болох хууль бус агнуурын эсрэг ажлыг нутгийн иргэдтэй хамтран амжилттай гүйцэтгэж байна.

Булган суманд 2018 оноос эхлэн нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын менежментийн аргачлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд Хангайн нурууны 1,370 км² талбай бүхий хүдрийн идээшил нутгийг хамгаалж байна.

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын 155.23 км² ойн талбайд хүдэр нь 1,000 га-д 1.62 бодгаль нягтшилтай гэж үнэлсэн.

Хүдрийн эрийг гирээ гэнэ. Бие гүйцсэн гирээ л заартай. Хагас шингэн хэлбэртэй заарыг биеэс салган авахад хуурай нунтаг болон хувирдаг. Гирээ нь орооны үед заараас ялгарах тансаг үнэрээр хосоо олж, мөн өөрийн эзэмшил газраа тэмдэглэдэг. Хүдрийг 25 гр заарын төлөө хууль бусаар авлаж мөхлийн ирмэгт авчирсан нь тун харамсалтай.

Өнөө үед заарыг түгээмэл гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт синтетик эдээр орлуулдаг болсноор энэ төрлийн зах зээл хумигджээ.

ТА ҮҮНИЙГ
МЭДЭХ ҮҮ?




10–14кг
БИЕИЙН ЖИН

- ♂ - ГИРЭЭ
- ♀ - ГИРЭГЧИН
- 👤 - ШОВШООРОЙ

90–95см
БИЕИЙН УРТ

65–70см
ХОНДЛОЙН ӨНДӨР



7-10 см урт

Гирээ нь дээд эрүүний яснаас гарсан 7-10 см соёотой.



25гр заар

Гирээ нь тансаг үнэрт заар ялгаруулах булчирхайтай.

21.4%

2018 оноос эхлэн Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т иргэдтэй хамтарсан гурван жилийн судалгаа, хамгааллын ажлын үр дүнд идлэг шонхрын тоо толгой 21.4 хувиар өссөн.





ИДЛЭГ ШОНХОР

Falco cherrug

Манай улсын хилээр давж буй зэрлэг амьтны худалдааны тэргүүн эгнээнд идлэг шонхор ордог.

Идлэг шонхорт нөлөөлж буй гол хүчин зүйл нь хууль бус худалдаа, цахилгаан шугам дагуу хүчдэлд цохиулах, үлийн цагаан оготны эсрэг ашигласан хорын нөлөө юм. Энэ зүйлийн шонхор нь том биетэй, догшин зан төрхтэй учраас Персийн булангийн Арабын орнуудад шувуулахуйн зорилгоор ашиглах сонирхол өндөр байдаг. Ялангуяа, эм бодгаль нь эрээс илүү том биетэй учраас сорчлон барьдаг.

Манай улс 1996-2015 оны хооронд нийт 24,748 шонхрыг экспортолсон нь улсын хэмжээнд CITES-ийн хүрээнд хийсэн зэрлэг амьтны худалдааны 97%-ийг бүрдүүлэв. Харин хууль бусаар хил давуулж буй шонхрын тоог нарийн тооцох боломжгүй.

Идлэг шонхрын тоо толгой 1999 онд 3,000 хос байсан бол 2004 онд 2,200 болж таван жилийн дотор 30 хувь буурсан. Харин 2010 оны эхээр гүйцэтгэсэн олон улсын судалгаагаар манай улсад 3,500 орчим шонхор байна гэж үнэлжээ. Өнөөдрийн байдлаар шонхрын тоо нарийн тодорхойгүй байгаа ч жилээс жилд харагдах нь багасаж, дотоодын шонхор

баригчид тааралдах нь ихсэж байна.

Идлэг шонхрыг мөхөл рүү дөхүүлж буй гол хүчин зүйл бол хууль бус худалдаа учраас түүнийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлэх нь чухал юм. Энэ зорилгоор ЛАСН-ээс Монгол Улсын хил, гаальд ажилладаг эрэлч нохойн илрүүлэх чадварыг сайжруулахын тулд ИБУИНВУ-ын Хилийн албатай хамтран ажиллаж, туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулав.

Түүнчлэн биологийн олон янз байдлын мониторинг судалгааг Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т 2018 оноос эхлэн зохион байгуулж байна. Уг судалгааны нэг зорилтот зүйл нь идлэг шонхор бөгөөд урт хугацааны мониторинг судалгааны талбайг тодорхойлж, улмаар хамгааллын менежментийн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулахад суурь судалгааны эхлэлийг тавьж байна.



6.4


ДУНДАЖ НАСЛАЛТ, жил

2–6

ЖИЛД ГАРГАХ ТӨЛИЙН ТОО

2–3

БЭЛГИЙН БОЙЖИЛТ ГҮЙЦЭХ ХУГАЦАА, жил



Идлэг шонхрыг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл барихыг хуулиар хориглоно.

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын хадан цохиот ойт хээр, голын шугуй зэрэг нь шонхрын өндөглөх таатай орчин болдог. Бид 2019 онд нийт долоон ангаахайтай гурван үүр олсон бол 2020 онд зургаан ангаахай бүхий хоёр үүр илрүүлэв. Хоёр жилийн турш гүйцэтгэсэн шугаман замналын тооллогын судалгаагаар бид идлэг шонхор байршин амьдрах боломжтой талбай 934.5 км² гэж үнэлэв.

Идлэг шонхор нь хагас нүүдлийн шувуу бөгөөд уг ОНТХГ төдийгүй Монгол оронд бие гүйцсэн бодгаль үлдэж, залуу шувууд Хятадын баруун хэсэгт очиж өвөлждөг онцлогтой.

Экосистем дэх үлийн цагаан оготно зэрэг мэрэгчдийн тоог хянах чухал үүрэгтэй.






ИДЛЭГ ШОНХОР НЬ ҮЛИЙН ЦАГААН ОГОТНО БҮХИЙ НУТАГТ ЭЛБЭГ ТОХИОЛДОНО

Идлэг шонхор нь олон зүйлийн жижиг хөхтөн, шувуу, шавжаар хооллодог. Монгол орны идлэг шонхрын үндсэн гөрөөл амьтад нь хөхтнөөс чичүүл, үлийн оготно, шувуунаас эвэрт болон Монгол болжмор юм. Идлэг шонхрын идэш тэжээлийн 60% орчмыг үлийн цагаан оготно дангаараа бүрдүүлдэг хэмээн Монгол орны идлэг шонхор номонд өгүүлжээ. Иймд үлийн цагаан ховордвол идлэг шонхор ч дайжин явна. Үлийн цагаан оготно элбэг нутагт идээшлэх шонхрын ангаахайн биеийн жин, хошуу, тарс, далавч, сүүлний хоногийн өсөлт сайн, илүү хурдан бойждог болохыг судлаачид тэмдэглэжээ.



38.1%

2018 оноос эхлэн Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т иргэдтэй хамтарсан гурван жилийн судалгаа, хамгааллын ажлын үр дүнд хээрийн бүргэдийн тоо толгой 38.1 хувиар өссөн.



ХЭЭРИЙН БҮРГЭД

Aquila nipalensis

Дэлхий дахинд тоо толгой нь маш хурдацтай цөөрч байгаа учраас БХОУХ-ны Улаан дансны шалгуураар 2015 онд олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” ангиллаас бууруулж “Эмзэг” болгосон.

Хээрийн бүргэд нь нүүдлийн шувуу. ОХУ-ын Европ тив дэх хэсэгт байрлах Бүгд Найрамдах Халимаг Улс (43°E)-аас зүүн тийш Казахстан, Кыргызстан, Монгол, Хятадын зүүн хэсэг хүртэл нутаглан өндөглөдөг. ОХУ-ын Европын хэсэг, Казахстан, Турк зэрэг улсад өндөглөдөг шувууд Ойрх Дорнод, Арабын хойг, Зүүн болон Өмнөд Африкт очиж өвөлждөг бол Алтай, Сибирээс зүүн тийш өндөглөдөг нь өмнөд болон зүүн өмнөд Азид өвөлждөг.

Дэлхий дахинд тоо толгой нь маш хурдтай цөөрч байгаа учраас БХОУХ-ны Улаан дансны шалгуураар 2015 онд олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” ангиллаас бууруулж “Эмзэг” болгосон.

Дэлхий даяар 31,372 бие гүйцсэн бодгаль бий.

Хээрийн бүргэдэд тулгарч буй гол аюул заналыг амьдрах орчны алдагдал, доройтлыг оролцуулахгүй дурдвал:

- 1) Цахилгаан шугамын дагуу хүчдэлд цохиулах,
- 2) Салхин сэнс мөргөх,
- 3) Идэш тэжээл бологч мэрэгчдийг устгахад ашигласан пестицидэд хордох. Өмнөд Азид диклофенак

хэмээх тариа тарьсан сэг зэмийг идээд хордож энддэг бол Монгол оронд үлийн цагийн оготныг устгах зорилгоор цацсан бромадиолонтой буудайнд хордож үхсэн оготно, үнэг, хярс зэрэг амьтны зэмийг идээд энддэг,

- 4) Ангаахайн үед гал түймэрт өртөх,
- 5) Үүрнээс ангаахайг авах хүний нөлөө зэрэг орно.

Хээрийн бүргэд 1-4 өндөг гаргаж, 45 хоног дарна. Ангаахай нь 60 орчим хоног үүрэнд байсны эцэст ниснэ. Үржлийн амжилт буюу төл авах эрчим нь идэш тэжээлийн хүрэлцээнээс хамааралтай байдаг. Монголд 37 үүрэнд гүйцэтгэсэн судалгаанаас үзэхэд идэш тэжээл хомсдолтой жилд нэг үүрнээс дунджаар 0.89 ангаахай амжилттай нисэж байв.

Хээрийн бүргэд нь идэш тэжээлийн хэлхээний дээд түвшний амьтан учраас экосистемд маш чухал үүрэгтэй. Бусад халин нисдэг шувуудын адил үлийн цагаан оготно, тарвага, зурам, чичүүл зэрэг мэрэгчийн тоо толгойг тогтоон барина.



Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын хадан цохиот уулын хажуу нь хээрийн бүргэдийн үүрлэх таатай орчин болдог. Уг ОНТХГ-ын нөхөрлөлийн идэвхтэн байгаль хамгаалагч 2019 оны хавар нэг ангаахайтай үүр олсон бол манай шувуу судлаачид 2020 онд зургаан ангаахай бүхий дөрвөн идэвхтэй үүр илрүүлэв. Шугаман замналын тооллого судалгаагаар хээрийн бүргэд байршин амьдрах боломжтой талбай 934.5 км² гэж үнэлсэн.

Энэхүү тоо толгойн өсөлт нь ЛАСН-ийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ойн хамгааллын менежмент сайжирч, шувуудын төл авалтын амжилтад эергээр нөлөөлж байгааг харуулж байна. Түүнчлэн, хээрийн бүргэдийн үндсэн гөрөөл амьтан болох тарваганы тоо толгой нэмэгдэж байгаатай холбоотой. Уг судалгааны явцад нөхөрлөлийн гишүүд зэрлэг амьтны шугаман замналын тооллого болон үүр бүртгэх, шувуудыг таньж тодорхойлох аргазүйд суралцсан.

ЦООХОР ИРВЭС

Panthera uncia



Дэлхийн дахинд амьдрах орчны хомсдол, хулгайн агнуураас шалтгаалж устгах аюулд орсон цоохор ирвэсийн хууль бус худалдааг ЛАСН таслан зогсоохын тулд ажиллаж байна.

Цоохор ирвэс нь дэлхий дээр 2.3 сая км² талбайд тохиолдох боловч тархцын цөм болох Төв Азийн уулархаг нутгаар сийрэг тархалттай. Дэлхийн хэмжээнд нийт тархцын 60 хувь нь Хятадад бий. Монгол орны цоохор ирвэсийн цөм нутаг нь Алтай нуруу боловч Хангай, Хөвсгөлийн уулсад мөн тохиолдоно.

Цоохор ирвэс ховордож буй гол шалтгаан нь малын хэт бэлчээрлэлт бөгөөд түүний сөрөг үр дагавраар амьдрах нутаг доройтож, гөрөөл амьтад хомсдож байна. Ирвэсийн арьс, яс, зарим эрхтнийг хууль бусаар худалдаалдаг. Жилд худалдаж буй ирвэсийн тоогоор таван улс дэлхийд тэргүүлдэг. Үүнд: Хятад (103-236), Монгол (34-53), Пакистан (23-53), Энэтхэг (21-45), Тажикстан (20-25) орно. “Зэлүүд тал” судалгаагаар 2005 онд ирвэс авладаг анчин өөрсдийгөө илчилж байсан бол 2015 онд нэг ч хүн байгаагүй нь тэдний хуулийн мэдлэг сайжирсныг харуулна. Харин Монгол Улс 1996-2015 оны дэлхийд устгах аюулд өртөж буй цоохор ирвэсийн 664 бодгалийг экспортолсон. 2013-2016 онд цагдаагийн байгууллагын

хураасан амьтны гаралтай эд эрхтний дунд дөрвөн ширхэг цоохор ирвэсийн арьс байв. Сүүлийн жилүүдэд ЛАСН холбогдох талуудтай хамтран Монгол дахь зэрлэг амьтны хууль бус худалдааг таслан зогсоохоор ажиллаж байна.

Цоохор ирвэс бартаа ихтэй өндөр уулын нууцлаг амьдралтай учраас байгалийн нөхцөлд хэд насалдгийг хараахан тогтоогоогүй байна. Харин хүний тэжээсэн тохиолдлоос үзэхэд 18 насалж байсан.

Ороо орох үе нь 1-3-р сар бөгөөд гинс хээлээ 90-105 хоног тээнэ. Ихэвчлэн 2-3 гүем төрүүлж, зургаан сарын турш хөхүүлнэ. Гүем эхний хоёр жил эхийн хамт амьдарна. Гинс 2-3 настайд, гэндүү дөрвөн настайд бэлгийн бойжилт гүйцдэг.

Цоохор ирвэсийн дэлхий дэх тоо толгойг одоогоор 2,710-3,386 хэмээн БХОУХ үзэж байгаа ч нарийн тоо баримт тодорхойгүй. Идээшил нутагтаа сийрэг тархалттай, нууцлаг амьдралтай учраас тоо толгойг нарийн үнэлэхэд хүндрэлтэй байдаг. Харин манай улсад 900-1,200 бий.

БӨХӨН

Saiga tatarica



Бөхөнгийн дэлхий дэх популяц 1970-аад оны дунд үед сая гаруй байсан бол эдүгээ 123.4–124.2 мянган бодгаль л үлдсэн. Өөрөөр хэлбэл, түүний арьс, мах, эврийг авахын тулд олноор авласаар сүүлийн 50 жилд популяцын хэмжээ 90 гаруй хувь буурсан.

Бөхөн нь Төв Азийн гурван бүсэд тохиолдоно. Үүнд Монгол, Казахстан, Бүгд Найрамдах Халимаг Улс орно. 1970-аад оны дунд үеэс дэлхий дээр 1.25 сая бөхөн байсан бол эдүгээ 123.4–124.2 мянган бодгаль л үлдсэн. Өөрөөр хэлбэл, сүүлийн 50 жилд популяцын хэмжээ 90 гаруй хувь буурсан гэсэн үг.

Цөлөрхөг хээрийн экосистемд ган, зуд зэрэг байгалийн үзэгдэл илүү тохиолдох болсон нь популяцын тоо толгойг бууруулсан нэг шалтгаан. Цөм нутагт малын бэлчээрлэлт ихтэйгээс шалтгаалж, 2017 онд малаас зэрлэг амьтанд халдварладаг мялзан төст өвчин дэгдэж Монгол дахь популяцын талаас илүү хорогдсон. Одоогоор манай оронд 5,000 орчим бодгаль бий.

Байгальд залуу хэрэгчинг сорчлон авласаар популяц дахь хүйсийн харьцаа өөрчлөгдсөн. Эврийг БНХАУ дахь ардын эмнэлэгт ашиглахын тулд үнэтэй худалдаж авдаг байв. ЛАСН-ээс зэрлэг амьтны хууль бус худалдааг таслан зогсоох зорилгоор гаалийн байгууллагатай нягт хамтран ажиллаж байна.

Монгол Улс нь зэрлэг амьтны худалдааны дамжуулагч улс болсон гэж “Ээлүүд тал” тайланд дурдсан байдаг. Түүний нэг жишээ бол манай улсаар дамжуулан Казахстан улсаас БНХАУ руу 100 ширхэг бөхөнгийн

эвэр тээвэрлэж байхад нь гаалийнхан хураасан тохиолдол бүртгэсэн. Манай улсад 2013-2016 оны хооронд илрүүлсэн зэрлэг амьтны гаралтай хэрэг, зөрчлийн тоо баримтаас үзэхэд 21 бөхөнгийн эд эрхтэнг хураасан байна. Уг судалгаанд Улаанбаатар дахь зарим захад бөхөнгийн эврийг 75 ам.доллараар зарж байгааг дурдсан байдаг.

Экологи, эдийн засгийн үнэлгээ нь хэржин 22 сая, хэрэгчин 20 сая билээ.

Бөхөнгийн зарим биологийн онцлогоос дурдвал хуурай шороотой орчинд зохилдсон монхор хамар нь ус болон дулааныг амьсгалаар алдахыг багасган чийглэж өгдөг. Хэрэгчин нь хоёр настайд, хэржин 7-8 настайд бэлгийн бойжилт гүйцнэ. Хэржин таван сарын туршид хээл тээж, ихэр янзага төрүүлнэ. Янзага 4-8 хоногтойд идээшилж эхлэх бөгөөд дөрвөн сарын турш эхийн сүүг хөхнө. Байгалийн нөхцөлд 10 жил орчим амьдардаг.



ХҮН БА БАЙГАЛЬ

Хүний амьдралын сайн сайхан нь эрүүл орчин, экосистемээс шууд хамааралтай. ЛАСН нь хүн ба байгалийн харилцан шүтэлцээг эрхэмлэж, нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгааллын менежментийг хэрэгжүүлсэн үр дүнг дараах бүлэгт танилцуулж байна.

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМТЫН МЕНЕЖМЕНТ

ОНТХГ-ын менежментийн арга хэлбэрүүдээс нутгийн иргэдийн оролцоотой байгалиа хамгаалах нь манай улсад хамгийн үр дүнтэй арга болж байна.



Өвөг дээдсээс өвлөн авч хэдэн үеэрээ гал голомтоо бадрааж ирсэн төрөлх нутгаа хайрлах сэтгэл, малчин хүний амьдрал, сайн сайхан бүхэн байгалийн хишиг буянаас шууд хамааралтай байдал нь нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал (community-based conservation)-ыг хөгжүүлэх, улмаар орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ)-ын менежмент хийх аятай хөрс суурь болдог. Гагцхүү зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш байгальд ээлтэй уламжлал ёс заншил бүдгэрэн, ашиг олзны төлөө үнэт зүйлсээ золиослох болсон өнөө үед өвгөдийн сургаалийг сануулж, орчин үеийн байгаль хамгааллын зарчмуудтай хослуулан мэдээлэл, мэдлэгээр малчдыг хангах нь байгалийн нөөцийн сайн засаглал тогтоох үндэс суурь юм.

1995 оноос нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал (НИТБХ)-ыг Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслөөр анх Монгол Улсад хэрэгжүүлснээс хойш энэ чиглэлийн олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж янз бүрийн үр дүнд хүрч олон сургамж авсан байдаг. ЛАСН-ээс Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т хэрэгжүүлсэн төсөл нь чухамдаа сүүлийн 25 жилд манай оронд хуримтлагдсан арвин туршлагыг ашиглаж, алдаа

сургамжийг харгалзан үзсэн үйл ажиллагаа ажээ. Нөгөөтгээгүүр Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ын менежментийн ангилал дотроос нутгийн иргэдийн нөөцийн эрхийг хэвээр нь үлдээж байгальд халгүй эдийн засгийн үйл ажиллагаа явуулангаа менежментийг малчид өөрсдөө зохистой байдлаар хийж болдог хэлбэр нь ОНТХГ юм. Иймээс БХОУХ-ноос тогтоосон ТХГН-ийн ангилалын V ба VI-ийн менежментийн зорилготой, түүнийг явуулж буй субъектийн хувьд ойролцоох нь манай ОНТХГ-ын хэлбэр байдаг. Тухайлбал, ангилал VI нь “байгалийн нөөцийг зохистой ашиглах замаар экосистемийг хамгаалах, улмаар зохистой ашиглалт, байгаль хамгааллыг зөв хослуулах” менежментийн зорилготой байдаг. Харин ангилал V нь “чухал ач холбогдол бүхий ландшафт/усан мандал болон хүн байгалийн шүтэлцээгээр буй болсон уламжлал, заншилд оршдог үнэт зүйлсийг хамгаалах, үргэлжлүүлэх” зорилготой ажээ. Ийм зорилгын хүрээнд нутгийн иргэдийн байгаль хамгаалалд оролцох эрх, үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, “Байгаль хамгаалах тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хууль зэрэг эрх зүйн актаар баталгаажуулж өгчээ. Гагцхүү ОНТХГ-ын


менежмент хийх институцийн тогтолцоо, шийдвэр гаргах засаглалын зарчим, үйл явц, түүнд оролцогч талууд, менежментийн арга хэрэгсэл зэрэг БХОУХ-ноос тогтоосон стандартыг манай эрх зүйн баримт бичгүүдэд хараахан тусгаагүй билээ. Иймд ЛАСН-ээс Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-т хэрэгжүүлсэн төслөөр энэхүү менежментийн загварыг туршин гаргаж ирсэн нь цаашид ОНТХГ-ын хууль эрх зүйн орчинг тодорхойлох, бусад ОНТХГ-ууд авч ашиглахад үлгэр жишээ болсон ач холбогдолтой. ОНТХГ-ын менежмент зөв зохистой шударга явагдах үндэс болдог БХОУХ-ноос тогтоосон менежментийн гол зарчмуудыг нөхөрлөлийн дүрэм, хурлын шийдвэр, тайлан зэрэг бүхий л үйл ажиллагаанд тууштай хэрэгжүүлж ажилладаг байна. Тухайлбал, ОНТХГ-т нутагладаг малчин бүр а) нөхөрлөлд эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх, ТХГН-ийн менежментийн зорилго, стратегийн асуудлаар санал хэлэх, бусадтай зөвшилцөх боломжтой; б) байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад оролцох, нөөц ашиглах эрхтэй, нөөцийг хамгаалах хариуцлагаа мөн үүрдэг; в) ОНТХГ-ын менежменттэй холбоотой зардал, үр ашгийг хоорондоо ижил тэгш хуваах, зөрчил гарсан тохиолдолд хурлаараа шударга зарчмаар шүүн хэлэлцдэг; г) ядуу, эмзэг

Сүүлийн жилүүдэд дэлхийн дахинд хүчээ авч буй ОНТХГ нь монголчуудын хувьд шинэ зүйл биш.

бүлгийн гишүүнээ хохироохгүй, дэмжих, аливаа нийгмийн гарзгүй байх; д) ОНТХГ-ын хамгааллын зорилгыг тодорхойлж, төлөвлөгөө гарган тууштай хэрэгжүүлдэг; е) биологийн олон янз байдлыг үр дүнтэй хамгаалахын сацуу оролцогч талууд болох нөхөрлөлүүд, аймгийн БОАЖГ, сумын ЗДТГ, Ойн анги зэрэг бүх талын ашиг сонирхлыг харгалзан асуудлыг шийдвэрлэх замаар нөөцийг арвич хямгачаар ашигладаг; ё) талууд үүрэг хариуцлагаа ойлгож тодорхой хуваарилах, бүрэн тайлагнах, хариуцлагаа хүлээх, аливаа санал шүүмжлэлд бие биедээ зохистой хариу өгөх; ж) хүний эрх ялангуяа, ирээдүй хойч үеийн эрхийг хүндэтгэж ажилладаг байна. ОНТХГ-ын малчид хурлаа ардчилсан байдлаар хийх, хамтын шийдвэр гаргах, ажлаа төлөвлөх, зэрлэг амьтан ургамлын мониторинг хийх, ой бэлчээр хамгааллын ажилд оролцох, амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд хамтын хүчээ хоршин нийгмийн баялгаа бэхжүүлэх зэрэг чухал олон ур чадварт суралцжээ. 100 гаруй км сунал тогтсон, хамгааллын чухал ач холбогдол бүхий энэ газрын нөхөрлөлүүд сумын Засаг даргатайгаа гэрээ байгуулж үйл ажиллагаагаа албажуулахаар төлөвлөн ажиллаж байна.



БУЛГАН СУМЫН
НӨХӨРЛӨЛҮҮДИЙН
ХОЛБООНЫ
БҮТЭЦ, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ



ХОЙД МОГОЙН ГОЛ-ТЭЭЛИЙН ОНТХГ

Нөхөрлөл байгуулж байгалиа хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах замаар орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагаа амжилттай өрнөж, зохих үр дүнд хүрээд байна.



Архангай аймгийн Булган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчийн 17-р тогтоолоор 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Хойд Могойн гол-Тээлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ) байгуулагдсан. Нийт 137,018 га талбайг хамрах ба Монгол Улсын тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн 28.3, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.14 дахь заалтыг үндэслэн орон нутгийн хамгаалалтад авсан. Уг ОНТХГ-т ЛАСН "Ойт хээрийн экосистем болон ховордож буй зүйлүүдийг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах төсөл"-ийг 2018 оноос хойш хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд "Булган сумын нөхөрлөлүүдийн холбоо" ГҮТББ байгуулагдан уг ОНТХГ-ын менежментийг нутгийн иргэд өөрсдөө хэрэгжүүлдэг болов. 2019 оны гуравдугаар сард уг холбоог үүсгэн байгуулснаас хойш 10 нөхөрлөл нэгдэж эдүгээ нийт 162 өрхийн 272 гишүүнтэй. Холбооны удирдлагад нөхөрлөл бүрийн дарга, удирдах зөвлөлийн төлөөлөгч, нарийн бичгийн дарга болон нөхөрлөлийн зарим гишүүн багтана. Нөхөрлөлүүд нь нөхөн сэргээх, зохистой ашиглах

замаар хөгжиж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх үйл ажиллагаа амжилттай өрнөж, зохих үр дүнд хүрээд байна. Цаашид нөхөрлөлийн гишүүд байгаль орчинд тулгамдаад байгаа олон асуудлыг шийдвэрлэх зорилготой.

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

Тус ОНТХГ-ын 10 нөхөрлөлд нийт 17 идэвхтэн байгаль хамгаалагч (ИБХ) ажиллаж байна. Сард хоёр удаа байгаль орчны эргүүл хяналтыг хамгаалалттай газарт тогтмол зохион байгуулдаг. Байгаль хамгааллын SMART системийн ашиглан байгаль орчны эргүүлийг гүйцэтгэж, 2019-2020 онд нийт 85 хууль бус мод бэлтгэл, агнуур болон бусад зөрчлийг таслан зогсоов. Мөн байгаль орчны хяналтын үйл ажиллагаанд ИБХ нараас гадна нөхөрлөлийн бусад гишүүд идэвхтэй оролцож байна. Нөхөрлөлийн гишүүд байгаль хамгаалалд идэвхтэй оролцсоноор хууль бус үйлдэл, зөрчлүүдийг таслан зогсоох тохиолдол өссөн.

ОЙН МЕНЕЖМЕНТ

Энэ чиглэлээр ойн анхдугаар зөвлөгөөн, ойн тухай эрхзүйн мэдлэг олгох сургалт, ойн сэргэн

Нөхөрлөлүүд
₮ **500 сая**
орчим төгрөгийн ашгийг
зөвхөн өрхийн үйлдвэрлэл,
байгалийн нөөцийн зохистой
ашиглалтаас олоод байна.

Нөхөрлөлүүдийн
хуримтлалын санд
₮ **80 сая**
төгрөг бүрдсэн.



ХАРИУЦСАН ТАЛБАЙД ЯМАР Ч ЗӨРЧИЛ ГАРДАГҮЙ БОЛСОН

Б. ЭНХ-АМГАЛАН, Идэвхтэн байгаль хамгаалагч

Арцат нөхөрлөлийн идэвхтэн байгаль хамгаалагчаар дөрөв дэх жилдээ ажиллаж байна. Миний үндсэн үүрэг бол зөвшөөрөлгүй мод огтлох, хууль бус агнуураас урьдчилан сэргийлэх юм. Нөхөрлөлийн гишүүд байгаль хамгаалалд оролцсоноор хулгайн агнуургүй болсон. Манай нутагт тарвага, хүдэр, чоно, буга, бор гөрөөс гэх мэт олон сайхан амьтан өсөж байна. Миний хариуцсан талбайд ямар нэгэн зөрчил гардаггүй болсон. Тухайлбал, сүүлийн гурван жилд хүдэр агнасан зөрчил огт гараагүй.



162

Холбоонд элссэн өрхийн тоо

272

Холбооны нийт гишүүн

ургалт, ойжуулалтын сургалт, ойжуулалтын мөчир бэлтгэх сургалт, байгалийн сэргэн ургалтын талбайг хаших, ойн цэвэрлэгээ, түймэр, хөнөөлт шавьжаас урьдчилан сэргийлэх зэрэг ажлыг зохион байгуулсан. Нөхөрлөлийн гишүүд 30 га талбайн ойг цэвэрлэж, 8.25 га байгалийн сэргэн ургалтын талбайг хашиж, гурван га талбайд ойжуулалт хийж ойн менежментийг хэрэгжүүлж байна.

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ

Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ-ын 37 цэгт хөрс, ургамлын мониторинг судалгааг гүйцэтгэсэн. Түүнчлэн нөхөрлөлд элссэн малчдад бэлчээрийн төлөв байдал, доройтлын шалтгаан, үр дагаврыг таниулж, тогтвортой ашиглах боломжийг сурталчлав. Мөн бэлчээрийг хариуцлагатай ашиглах журмын төслийг хэлэлцүүлэн малчдын саналыг тусгалаа. Энэ хүрээнд 2019 онд 84 удаа 1,988 хүн, 2020 онд 75 удаа семинар, уулзалт, санал асуулгын ажил зохион байгуулж давхардсан тоогоор нийт 5,667 малчин оролцжээ. Зарим ажлыг онцолбол:

- 6 хэлэлцүүлэгт **456 малчин** оролцсон,
- 3 нөхөрлөл зун, намрын **5,000 га** бэлчээрийг чөлөөлсөн,
- 7 нөхөрлөл **60 хоног** бэлчээрээ амрааж нүүсэн,
- **5 булгийн** эхийг хашиж хамгаалсан,
- **15 га** талбайд овъёос тариалсан,
- **240 тонн** ногоон тэжээл бэлтгэсэн,
- **2,649 га** талбайг хамгаалж, хадлан бэлтгэсэн.

АМЬЖИРГААГ ДЭМЖИХ

Нөхөрлөл бүрийн нөөц боломжид үндэслэн өсөн нөхөрлөлийн бизнес төлөвлөгөөг боловсруулав. Тэд цагаан идээ, газар тариалан, аялал жуулчлал, блок цохих чиглэлээр ажиллахаар

төлөвлөсөн. ЛАСН-ээс тус өсөн нөхөрлөлд 60 сая төгрөгийн зардлын дэмжлэг үзүүлсэн. Нөхөрлөлүүд бизнес төлөвлөгөө хэрэгжүүлж 2020 оны есдүгээр сарын байдлаар 396 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. 2019 онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Экологид ээлтэй бүтээгдэхүүн-2019”, Архангай аймагт зохион байгуулсан “Архангай түншлэл-2019” үзэсгэлэн худалдаанд нөхөрлөлийн гишүүд цагаан идээ, био нүүрсэн бүтээгдэхүүнээр оролцож 30 гаруй сая төгрөгийн борлуулалт хийв. Түүнчлэн нөхөрлөлийн гишүүд морин аялал, гэр буудлын үйлчилгээ эрхлэх, зочлох үйлчилгээний ур чадвар олгох сургалтад хамрагдсанаар 2019 онд 30 гаруй сая төгрөгийн орлого олжээ. 2020 онд 240 машин цэвэрлэгээний мод гаргасан бөгөөд аймгийн төвийн иргэдэд нэг машин модыг зах зээлийн үнийн хагасаар буюу 150 мянган төгрөгөөр худалдсан. Түүнчлэн, гурван жилийн хугацаанд 30 га талбайг цэвэрлэж, 60 сая төгрөгийн орлого олсон.

ДУНДЫН ХУРИМТЛАЛЫН САН

Байгалийн нөөцийн хамтын менежментийн 8 нөхөрлөл тус бүрдээ дундын хуримтлалын сан байгуулж, олон улсын CARE байгууллагын хуримтлалын бүлгийн аргачлалын дагуу сургагч багшийн заавраар ажиллаж байна. Хуримтлалын бүлэгт тухайн нөхөрлөлийн ахлагч, нарийн бичгийн дарга, хуримтлалын хайрцагч хариуцагч, мөнгө тоологч зэрэг таван хүн оролцоно. Одоогоор 10 нөхөрлөлийн 272 гишүүнээс 224 буюу 82.3 хувь нь хуримтлалын санд мөнгө хуримтлуулж байна. Хуримтлалын сан нь нийт 80 сая орчим төгрөгтэй. Тус сангаас гишүүд зээл авч санхүүгийн хэрэгцээгээ бүрэн хангахаас гадна өөрийн хуримтлуулсан мөнгийг 22-25 хувиар өсгөж байна.



Хадлангийн талбайгаа хашин хамгаалж байна.



Суулгац цуглуулж нөхөн сэргээлтэд ашиглав.

ДУРТАЙ НЬ БУУ БАРЬЖ МАШИНТАЙ ДАВХИАД АН АВЛАЖ ЧАДАХГҮЙ БОЛСОН



Ц.Төрхүү, Булган сумын засаг дарга

ЛАСН-ийн хэрэгжүүлсэн төсөл нутгийн иргэдийн дунд гурван том өөрчлөлтийг авчирсан. Нэгдүгээрт, эвлэлдэн нэгдэх хандлага нэмэгдсэн. Хоёрдугаарт, иргэд өөрсдөө дүрэм журам санаачилдаг болсон. Гуравдугаарт, иргэд нэгдэн үйлдвэрлэл эрхэлж эхэлсэн.

1) Хамтын зохион байгуулалтад орж, хууль бус мод бэлтгэлийг 80 хувиар бууруулсан. Түүнчлэн зэрлэг амьтан, ургамлын хамгаалалт сайжирч, дуртай нэг нь буу барьж машинтай давхиад ан авлаж чадахгүй болсон. Мөн нутгийн иргэд өөрсдөө байгалийн нөөцийг зөв зохистой ашигласнаар сумын хөгжилд хувь нэмэр оруулж болохыг харууллаа. Тодруулбал, өмнө нь наймдугаар сар гараад л болц гүйцээгүй самрыг замбараагүй түүж эхэлдэг байлаа. Харин одоо есдүгээр сарын 15 хүртэл нөхөрлөлийн зохион байгуулалт дор самар огт түүхгүй ба самрын болц гүйцэхэд иргэд өөрсдөө цэгцтэй зохион байгуулалтад орж, байгальд ээлтэй байдлаар түүж байна. Ингэснээр сумын төсөвт 336 сая төгрөгийг зөвхөн самрын орлогоос оруулсан. Энэ нь нөөцийг зохистой ашиглавал эдийн засгийн хувьд ч үр өгөөжтэй байдгийг харуулсан гайхалтай жишээ юм. Үүнээс

сургамж авч захиргааны зүгээс сумандаа ойн хулгайг бүрэн зогсоох зорилгоор гурван шинэ нөхөрлөл байгуулсан.

2) Иргэд бэлчээрийг зохистой ашиглах журам санаачилж сумын ИТХ-д санал оруулсан. Тус журмыг удахгүй хурлаар хэлэлцэнэ. Үүгээр нутгийн малчдын бэлчээр ашиглалтыг зохицуулна. Өөрөөр хэлбэл, одоогийн төрийн мэдлийн бэлчээрийг сумын засаг дарга, багийн дарга, нөхөрлөл хоорондоо гэрээ байгуулан зохистой ашиглана. Өвөлжилт хүндэрсэн тохиолдолд өөр аймаг сумаас дуртай нэг нь нүүж ирээд нутаглах боломжийг хааж, нутгийн малчид хохирол багатай даван туулах бололжийг бүрдүүлнэ. Малчид сумын захиргаатай гэрээ байгуулснаар бэлчээр хамгаалах хариуцлага нь нэмэгдэж буй сайн талтай.

3) Гуравдугаарт, нөхөрлөл байгуулагдсаны өөр нэг сайн тал нь гишүүд хуримтлалын сан бүрдүүлээд өрхийн үйлдвэрлэл хөгжүүлэх төсөл санаачилж байна. Жишээ нь, цагаан идээгээ хамтран боловсруулаад эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээлд нийлүүлэх, ойн цэвэрлэгээг хамтран хэрэгжүүлж модны зах зээлд нийлүүлэх, газар тариалан хамтран эрхлэх гэх мэт. Энэ нь зөвхөн гишүүдэд үр өгөөжөө өгөөд зогсохгүй сумын хэмжээнд томоохон хөрөнгө оруулж байна.



Булган сумын нөхөрлөлүүдийн холбоо ГҮТББ-ын гүйцэтгэх захирал Н. Мөнхтүвшинтэй ярилцлаа.

Булган суманд хэрэгжүүлж буй төслийн талаар товч танилцуулна уу?

Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол хурдацтай явагдаж байгаа энэ үед хамтын хүчээр зогсоох, даван туулах үр дүнтэй аргуудын нэг нь олон улсад амжилттай хэрэгжиж байгаа ОНТХГ-ын менежмент юм. Энэ менежментийн онцлог нь нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлаж байгаль хамгааллыг хэрэгжүүлдэг. Дан ганц байгаль төдийгүй тухайн иргэний амьдрал, улсын эдийн засагт ч сайнаар нөлөөлнө.

Төслийг хэрэгжүүлж эхлэхэд хүндрэл бэрхшээл байсан уу?

Малчдыг нэгтгэх, цуглуулах их хүндрэлтэй байсан. Учир нь малчид сумын төв, өөр хоорондоо хол зайтай нутагладаг учраас мэдээлэл өгөх хурал зохион байгуулахад ирц багатай байв. Тиймээс бид хамтын нөхөрлөлийн хуримтлалын санг байгуулах замаар шийдсэн. Энэ нь ямар учиртай вэ гэхээр малчид өөрсдөө нэгдээд нөхөрлөл байгуулаад, дүрэм журмаа зөвшилцөж батлаад дундын хуримтлал үүсгэхийг хэлдэг. Ингэж хуримтлал үүсгэснээр иргэдийн оролцоо идэвхждэг. Хүн

бүр тодорхой хэмжээний санхүүгийн хариуцлага хүлээдэг учраас оролцоо илүү сайжирсан.

Иргэдийн амьжиргаанд ямар өөрчлөлт гарсан бэ?

Нөхөрлөл бүр өөр өөр үйлдвэрлэл эрхлэх боломжтой. Зарим нөхөрлөл цагаан идээ боловсруулдаг бол зарим нь барилгын блок цохих жишээтэй. Тухайлбал, манай Баянбулаг нөхөрлөл ногоон тэжээл тариалах төхөөрөмжийн дэмжлэг авч, нийт 15 га талбайд тариалж, 240 тонн тэжээл хураан авч, 52 сая төгрөгийн орлого олсон. Тариалах ажилд нөхөрлөлийн гишүүн бүр оролцож, ашгийн хувиа хүртдэг. Орлогынхоо 10 хувийг нөхөрлөлийн нийгмийн хуримтлалын сандаа оруулдаг нь иргэдийг нэгтгэж өгдөг. Мөн бид малчдын орлогын эх үүсвэрийг солонгоруулах зорилгоор янз бүрийн салбарыг хөгжүүлэхийг хичээж байна. Жишээ нь, “Тэмээн чулуу” нөхөрлөлийн гишүүдийг аялал жуулчлал хөгжүүлэх сургалтад хамруулсан. Ялангуяа, морин аялал, байгалийн аялал жуулчлалыг системтэй хөгжүүлэх тухай заасан. Одоогийн байдлаар аяллын маршрут

52

Баянбулаг нөхөрлөл ногоон тэжээл тариалах төхөөрөмжийн дэмжлэг авч, 240 тонн тэжээл хурааж 52 сая төгрөгийн орлого олсон.



бүхий вэб сайтыг онлайн орчинд байрлуулахаар ажиллаж байна.

Дундын хуримтлалын сан ямар ач холбогдолтой вэ?

Малчид өөрсдөө нэгдэн, дүрэм журмаа зөвшилцөж батлаад нэгдсэн хуримтлал үүсгэснээр иргэдийн нийгмийн оролцоо идэвхжиж, санхүүгийн хариуцлагатай болж, малчид заавал банк гэхгүй өөрсдөө өндөр хүүтэй хуримтлал үүсгэн амьжиргаагаа өөд татах боломжтой. Мөн дундын хуримтлалын сан нь төв суурин газраас алслагдмал амьдардаг тэдэнд тулгардаг хэд хэд асуудлыг шийдэж өгдөг. Одоогоор манай бүх нөхөрлөлийн дундын хуримтлалын санд 80 орчим сая төгрөг бүрдсэн. Нэгдүгээрт, малчдын санхүүгийн үйлчилгээ авахад тулгардаг бэрхшээлүүдийг шийддэг. Учир нь малчинд бичил зээл авах шаардлага тодорхой хугацаанаас хамааран гардаг. Урьд нь сумын төв орж зээл хөөцөлдөхөд цаг хугацаа алдах, зээл нь бүтэхгүй, эсвэл хэтэрхий өндөр хүүтэй зэрэг асуудал тулгардаг байв. Энэ үед харьяалагдах нөхөрлөлийнхөө дундын хуримтлалын “зээлийн сан”-аас хэрэгцээтэй зээлээ бага хүүтэй, шуурхай авчихдаг. Жишээ нь, “Наранбулаг” нөхөрлөлийн малчин Болд хүүгийнхээ сургалтын төлбөрийг яаралтай хийх шаардлага гарна. Тэгээд хуримтлалын сангаасаа зээл аваад асуудлаа шийдсэнээр хүүгийнхээ боловсролыг тасалдуулахгүй байж чадна. Тиймээс хүмүүс хуримтлалын санд сэтгэл хангалуун байдаг. Хоёрдугаарт, хуримтлалын санд “нийгмийн сан” гэж бий. Зээлийн сангаас зээлийн асуудлаа шийддэг бол, нийгмийн сангаар нөхөрлөлийн зохион байгуулж буй үйл ажиллагаанд зарцуулах, гишүүнд тулгарсан нийгмийн хүндрэл бэрхшээлд дэмжлэг үзүүлэх, байгаль хамгаалагчийн эргүүл хамгаалалд шаардагдах зардлыг хангадаг. Тухайлбал, Арцат нөхөрлөлийн өндөр настан

ТЭДНЭЭС ТЭВЧЭЭРТЭЙ, АМГАЛАН ТАЙВАН БАЙХЫГ СУРСАН



Д. ОТГОНБАЯР, Идэвхтэн байгаль хамгаалагч

Тэх харайх нөхөрлөлийн гишүүн. Байгаль хамгаалагч болоод зургаан жил болж байна. Нэг ч гэсэн мод огтлуулахгүй, зэрлэг амьтан агнуулахгүйн тулд гэртээ байхаас илүү ойдоо байх дуртай. Би долоон хоногт гэртээ хоёр л хонодог бусад үед хариуцсан уулын аманд малаа хариулаад байгаль хамгааллын ажлаа хийдэг. Өндөрлөг газар амьтдаа хараад, дурандаад суух л хамгийн сайхан даа. Ялангуяа янгир болон хүдэр харж суухад сүрлэг сайхан санагддаг. Би тэднээс тэвчээртэй, амгалан тайван байхыг сурсан.

ЛАСН-ийн төсөл хэрэгжсэнээс хойш иргэдийн оролцоо эрс сайжирч амьдрал ахуй нь ч сайжирсан. Олон сайхан сургалт хөгжлийн үйл ажиллагааг явуулдаг. Миний хувьд зэрлэг амьтны судалгаа хэрхэн хийх, мөр шөргөөснөөс нь амьтныг таньж тодорхойлохыг сурсан. Мөн хууль бус агнуур, мод огтлох зөрчилгүй болсноор амьтны тоо ч жилээс жилд өссөөр байна. Тухайлбал, манай нутагт өмнө нь 11 янгир байсан бол одоо 20 болж өссөн. Түүнээс гадна нэн ховор хүдэр хүртэл өсөж байгаа. Миний ажиллаж байгаа хэсэгт 30 орчим хүдэр байна.



Нараа ганцаараа амьдардаг бөгөөд саяхан түлээ нь дуусчихсан. Тэгээд нөхөрлөлийн гишүүд мод түүж хагалаад бэлдээд өгсөн. Мөн хамгийн сүүлийн тайлангаас харахад нөхөрлөлүүдийн нийгмийн сан нь байгаль хамгаалах үйл ажиллагаанд түлхүү зарцуулагдсан. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд оролцсон гишүүдийн хоол унд, төхөөрөмжийн зардлыг нийгмийн сангаас гаргадаг. Гуравдугаарт, хуримтлалын сан нь малчин иргэдэд хуримтлал үүсгэх дадлыг суулгадаг. Учир нь хуримтлалын сангаас жилийн эцэст 25 хувь орчим хүүгийн нэмэгдэлтэй ногдол ашиг авдаг. Нэг хүн сард хуримтлуулсан мөнгөн дүнгээс хамааран хамгийн багадаа 500 мянгаас нэг сая хүртэлх төгрөг авдаг. Хүүгийн нэмэгдэл авахаар банканд хадгалуулснаас илүү ашигтай. Эхнэр, нөхөр хоёр хуримтлалын санд оролцдог гэхээр нийлээд хоёр сая төгрөгийн хуримтлал дээр нь хүү нэмбэл 2,500,000 төгрөг авч байгаа юм. Ногдол ашгаа жилийн эцэст авбал хаврын бэлтгэл хангах, өвс тэжээл авах зэрэг малчдын хамгийн хүнд үеийг саадгүй туулахад дэм болдог.



ӨТГӨН САЙХАН ОЙГ ҮР ХОЙЧДОО ҮЛДЭЭХИЙГ ЗОРЬДОГ

Ч. ЖАВЗАН, Буурал хангай нөхөрлөлийн дарга

Манай нөхөрлөл 2019 оны 12-р сард байгуулагдсан ба 11 айл нэгдэж 20 гаруй гишүүнтэй болсон. Эмэгтэй даргатай цорын ганц нөхөрлөл.

Манай нөхөрлөлийн үндсэн үйл ажиллагаа бол мод үржүүлж ойн нөхөн сэргээлт хийх. ЛАСН-ээс бидэнд мод үржүүлэх, ногоо тариалах зориулалттай 6х10 хэмжээтэй хоёр хүлэмжийн дэмжлэг үзүүлсэн. Бид туршилтын журмаар эхний хүлэмжид өргөст хэмх зэрэг нарийн ногоо тарьсан бол хоёр дахид бургас, шинэс зэрэг мод тариалсан. Одоогийн байдлаар 20 орчим зулзаган мод амжилттай ургаж байна. Энэ жил бид хүлэмжид тарих суулгацын тоог 100 болгохоос гадна өнгөрсөн жил бусад 10 нөхөрлөлийн хамт цэвэрлэсэн түймэрт өртсөн ойн талбайг хашиж нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөтэй байна. Байгалиа нөхөн сэргээж нөөцийг зохистой ашиглахаас гадна сумандаа мод үржүүлгийн төвийг байгуулж гишүүдийн өрхийн амьжиргааг сайжруулахад манай төсөл үнэтэй хувь нэмэр оруулж чадна гэж боддог.

Өтгөн сайхан ойг үр хойчдоо үлдээгээд, тэд маань ирээдүйд өмнөх үеэрээ бахархаасай гэж хүсдэг. Тиймээс ч хүүхдүүдээ амьтай модыг хайрлаж, зэрлэг амьтнаа агнахгүй байхыг үргэлж захидаг.



Нөхөрлөлийн гишүүд ажиглалт судалгаа, эргүүл хяналтыг тогтмол гүйцэтгэдэг.



Хойд Могойн гол-Тээлийн ОНТХГ



АМЬД БАЙГАЛИА ХАМГААЛЖ, ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭСЭН ШИЛДЭГ ТУРШЛАГА

Намиб улс нь ОНТХГ-ын аргачлалыг хэрэгжүүлсэн 23 жилийн түүхэнд 223,000 хүний амьдралыг бүрэн өөрчилжээ.



Хирс (*Diceros bicornis*)

Дэлхийн эдийн засгийн нийт өсөлтийн 10 хувийг аялал жуулчлалын салбар дангаараа бүрдүүлдэг гэвэл та итгэх үү? Энэ салбар 319 сая ажлын байрыг бий болгож, байгалийн нөөцийн хууль бус худалдаанаас тав дахин их хэмжээний орлогыг дэлхийн эдийн засагт оруулдаг. Хамгийн сонирхолтой нь нийт аялагчдийн гуравны нэг нь онгон байгаль, зэрлэг амьтан ажиглахыг зорьдог. Зөвхөн 2018 онд амьд байгаль харуулах аяллын төрөл 21.8 сая ажлын байрыг бий болгож 343.6 тэрбум ам.доллар буюу Хонконг, Өмнөд Африкийн эдийн засгийг нийлүүлсэнтэй тэнцэхүйц хэмжээний өгөөжийг дэлхийн эдийн засагт оруулжээ. Африкийн зарим оронд сүүлийн

жилүүдэд нутгийн иргэдийн оролцоотойгоор байгаль хамгаалах менежментийг амжилттай хэрэгжүүлэн амьд байгаль ажиглах аяллыг хөгжүүлж уул уурхай, хууль бус худалдаанаас илүү эдийн засгаа сэргээж чаджээ.

ОНТХГ-ЫН ҮЛГЭР ЖИШЭЭ БОЛСОН НАМИБ

ОНТХГ-ын аргачлалыг хэрэгжүүлсэн 23 жилийн түүхэнд 223,000 хүний амьдралыг бүрэн өөрчилжээ. Түүнчлэн Намиб улсын салбарын яамны үндсэн зорилго зөвхөн амьд байгалийг хамгаалаад зогсохгүй, нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахыг зорьдог. ОНТХГ-ын тоог

нэмэгдүүлж, амьд байгалиа хамгаалсны үр дүнд нутгийн иргэдийн хамгийн чухал орлогын эх үүсвэр нь аялал жуулчлал, тэр дундаа зэрлэг амьтан ажиглах аялал болсон байна. Намибад доорх эерэг өөрчлөлтүүд гарчээ.

1. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛ

Намибын нийт нутгийн 39.5 хувь тусгай хамгаалалтад байдаг. Үүнээс 20.2 хувийг нутгийн иргэдийн менежмент дангаараа хариуцдаг. Ингэснээр тухайн ОНТХГ-т буй байгалийн нөөцийг захиран зарцуулах эрх нутгийн иргэдэд шилжиж байгаль хамгаалал сайжирсан байна.

2. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

Намиб нь ОНТХГ-ын загвар улс болохын хувьд аялал жуулчлал, тогтвортой агнуураас олох эдийн засгийн өгөөж өндөр. Аялал жуулчлалын орлогын талаас илүү хувь нь нутгийн иргэдийн гар дээр очдог. Намиб улсын 1990 оноос оруулсан хөрөнгө оруулалт болон амьд байгалийн аялал жуулчлалаар бий болсон эдийн засгийн үр өгөөжийн харьцааг доорх графикаас харж болно. Тухайлбал, 2019 онд 6.8 сая ам.долларыг ОНТХГ-т

зарцуулаад 65 сая ам.долларын орлогыг олжээ.




3. НУТГИЙН ИРГЭДИЙН ЧАДАВХЫН ӨСӨЛТ

ОНТХГ-уудыг байгуулж, иргэдийг зохион байгуулалтад оруулсны дараа сургалт, хөгжлийн арга хэмжээ зохион байгуулж малчин, тариаланчдын чадавхыг дээшлүүлсэн. Ингэснээр тэдний нийгэмд эзлэх байр суурь батжин, оролцоо нэмэгддэг. Тухайлбал, Намибын ОНТХГ-ын нөхөрлөлд эмэгтэй удирдагчдын тоо өсөж, нийгмийн оролцоог дэмжсэн эерэг өөрчлөлт гарчээ.

4. ЗЭРЛЭГ АМЬТНЫ ТОО ТОЛГОЙН ӨСӨЛТ

ОНТХГ-ын тоо нэмэгдэж малчин, зэрлэг амьтны хоорондын зөрчил буурснаар дэлхийд ховордож буй арслан, Африкын заан, хирс зэрэг амьтдын тоо толгой өссөн. Тухайлбал, Намиб улсад зааны тоо толгой 1995 онд 7,500 байсан бол 2016 оны байдлаар 22,800 болтлоо өсжээ. Мөн Намиб нь зэрлэг хирсийн хамгийн том популяц бүхий орон юм. Ийнхүү ОНТХГ-ын менежментийн амьд байгаль, хүн төрөлхтөнд оруулж буй өгөөжийг үнэлж баршгүй.

\$ (сая доллар)



Эх сурвалж: <https://www.communityconservationnamibia.com/>

ЭЛСЭН ДАЛАЙН ХӨЛӨГ ОНГОЦОО АВАРЪЯ

Хавтгай бол говь нутгийн чимэг, нэн ховордсон байгальд байх ёстой амьтан гэж ГИДЦГ-ын орчны бүсэд амьдардаг малчид үзэж байна.



Хавтгай (*Camelus bactrianus*)

Дэлхийд “Элсэн далайн хөлөг онгоц” хэмээн алдаршсан хавтгай Монголд байсан тухай бидний үр хойч зөвхөн түүхийн хуудаснаас л унших эмгэнэлт тавилан ойрхон байна. Бид дэлхийд ховорхон хавтгай тэмээ Монголд байдаг хэмээн ам уралдан гайхуулдаг хэрнээ энэ сүрлэг амьтныг хайрлан хамгаалж, амьдрах таатай орчноор хангаж чадаж байна уу. Эдүгээ зөвхөн Монгол болон Хятадын Шинжааны нутагт 1,000 хүрэхтэй үгүйтэй үлдээд буй хавтгайн сүргийг хайрлан хамгаалах шаардлага манай улс төдийгүй хүн төрөлхтний өмнө тулгараад байна.

ЛАСН-ийн 2014 онд хийсэн хамгийн сүүлийн тооллогоор Монгол нутаг дахь хавтгайн тоо толгой 500 хүрч буурчээ. Хавтгай тэмээний тоо толгой жилээс жилд цөөрч, түүний амьдрах орчинтой холбоотой цөөнгүй асуудал тулгараад буй ч энэ чиглэлийн дорвитой судалгаа мэдээлэл тун бүрхэг, ховор байсан юм. Харин ЛАСН Үндэсний газарзүйн нийгэмлэгийн санхүүжилтээр анхаарал шаардаж буй хавтгайн



тухай судалгааг 2018 оноос эхлүүлсэн. Монгол орны хавтгайн хамгийн сүүлчийн популяцыг тэтгэдэг чухал нутаг нь ГИДЦГ-ын А хэсэг. Орчны бүсэд амьдарч буй малчдын нийгмийн судалгаа, хавтгай хамгааллын талаарх ойлголт, хавтгайн бэлчээрийн ашиглалтын өнөөгийн хандлагыг олон нийтийн санаа бодолд тулгуурлан тодорхойлсон. Энэхүү судалгаанд Говь-Алтай, Баянхонгор аймгийн 303 малчин өрх хамрагдсан байна. Судалгаанаас харахад малчдын дунд хавтгайн талаарх мэдлэг ойлголт ерөнхийдөө тааруу, дутмаг байгаа нь харагджээ. Тодруулбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 37 хувь муухан, 30.7 хувь нь дунд зэрэг мэдэж байсан бол 0.7 хувь нь огт мэдэхгүй. Харин 26.4 хувь сайн, ердөө 5.3 хувь маш сайн мэдлэгтэй гэсэн дүгнэлт гарчээ. Хавтгай нь орооныхоо үед малчдын тайлаг хөөх, ингэ хураах, бууртай ноцолдох, буур хазаж хөөх гэх мэт хүндрэлийг нутгийн малчдад учруулдаг нь судалгааны явцад тодорхой болсон байна. Малчдын дийлэнх нь

хавтгай нь тухайн нутгийн чимэг, нэн ховордсон, байгальд байх ёстой амьтан хэмээн үздэг. Гэхдээ цөөнгүй малчин гэрийн тэмээний үржил угсааг сайжруулах зорилгоор хавтгайтай эрлийзжүүлэх сонирхолтой байдаг аж. Үүнээс гадна хавтгайн тоо толгой цөөрч буй шалтгааныг тодруулахад уур амьсгалын өөрчлөлт, усны дутагдал, махчин амьтдын нөлөө, уул уурхай, бэлчээрийн доройтол, цөлжилт зэрэг хамгийн хүчтэй нөлөө үзүүлж буй аж. Эдгээрээс говийн бүс нутаг дахь усны эх үүсвэрийн дутагдал, үүнтэй холбоотой асуудал нь Монгол оронд хавтгайн тоо толгой цөөрч буй гол шалтгаан болоод байна. ГИДЦГ-тай ойр орших малчид бэлчээрийг зүй зохистой ашиглах, хуваарилах, нөөцлөх, хамгаалах ёстой гэж үздэг ч бодит байдал дээр үүнийг хэрэгжүүлэхдээ хойрго ханддаг. Цаашлаад зарим малчид тусгай хамгаалалттай газрын хил орчмоор ялангуяа Цагаан богд, Идрэнгийн нуруу, Эхийн гол, Өвөрсухайт, Өвөрбэл, Арсухайт, Шивээт хайрхан, Тахийн шар нуруу зэрэг газар нутаглаж хавтгайтай бэлчээр давхцах тохиолдол ч цөөнгүй. Ялангуяа малчдын ихэнх нь Идрэнгийн нуруу, Цагаан богд, Эхийн голын нутгаар нутаглаж, хавтгайтай бэлчээр “булаацалддаг” байна. Иймд бэлчээр давхцаж буй энэ хэсэг нутгийн бэлчээрийн судалгаа хийх, цаашид бэлчээр давхцлаас үүдэн гарч буй асуудлуудыг улам тодруулах, тодорхой шийдвэрийг зохих түвшинд холбогдох байгууллагууд гаргах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байгааг ЛАСН-ийн судалгаанд дурдсан байна. Хавтгай генетикийн хувьд цэвэр байгалийн зэрлэг популяци. Гэрийн тэмээ болон хавтгай тэмээний хооронд генийн ялгаа гурван хувь байгааг илрүүлсэн бөгөөд тус тусдаа биеэ даасан зүйл болохыг харуулсан судалгаанууд ч бий. Биологийн хувьд гэрийн тэмээ болон хавтгай тэмээний хооронд үржил явагдаж эрлийз бодгаль буюу бэсрэг төрүүлж байна. Өнөөдөр Монгол оронд байгаа хавтгай тэмээний 20 орчим хувьтай дүйх хэмжээний эрлийз бодгаль байгаа нь анхаарлын гадна үлдээж үл болох асуудал. Нутгийн иргэд эрлийз тэмээг сонирхох гол шалтгаан нь түүний хурд. Сүүлийн жилүүдэд орон нутаг, аймаг, улсын хэмжээнд өндөр бооцоо, шагнальтай, тэмээний уралдаан олонтоо зохиогдох болсон нь малчдын хурдан тэмээтэй болох хүсэл сонирхлыг өдөөсөн байна. Гэхдээ эрлийз тэмээг уралдуулахгүй байх, тэмцээнээс хасах зэрэг арга хэмжээ авсан нь бэсрэг тэмээг хязгаарлах хөшүүрэг болж



байгаа ажээ. ЛАСН-ийн хийсэн судалгаа нь нэн чухал ач холбогдолтой боловч Монгол оронд төдийгүй дэлхийд ховор, нэн ховорт тооцогдох зүйлүүдийн генетик олон янз байдал, нөөцийг цэврээр хадгалах, хамгаалах, зохистой ашиглахын тулд тэдгээрийн эрлийзтэй холбоотой асуудлыг эрхзүйн хүрээнд цэгцлэх ажил монголчуудыг хүлээсээр байна. Уг нь ГИДЦГ болон орчны бүсэд олон тооны төсөл хөтөлбөр хэрэгжиж буй ч малчдад төслийн үйл ажиллагаа, үр дүнгийн хүртээмж тааруу, уялдаа холбоо багатай. Иймд энэ бүс нутгийн хэмжээнд хийгдэж буй судалгаа шинжилгээ, төсөл хөтөлбөрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, төслүүд танилцуулга, тайлан мэдээгээ малчдад хүргэж мэдээллээр хангах нь чухал байна. Нутгийн зэрлэг амьтдыг хамгаалахад малчдыг татан оролцуулах нь аль аль талдаа үр дүнтэй аргад тооцогдож байна. Эцэст нь, их говийн чимэг болсон хавтгайд эрлийзжин, устаж үгүй болох аюул тулгараад байна. Энэ тэнгэрлэг амьтад монголчуудаас халамж хамгаалал, Монголын төр засаг, холбогдох байгууллагуудаас бодлого зохицуулалт хүсэж байна. Бид устаж үгүй болох ирмэгт тулсан хавтгайн сүргийг одоо л хайрлаж хамгаалахгүй бол ирээдүйд “Ийм сүрлэг сайхан амьтан Монголд байсан юм” хэмээн дурсан ярьж, зөвхөн гэрэл зургийг нь л үр хойчдоо үзүүлэх үү. Уг нь энэ хосгүй ховор амьтан тэнэгэр говьдоо идээшилж, Дорнын говиос Монголд байдаг хэмээн дэлхийд зарлуулж, түүгээр бахархаж байвал хичнээн сайхан.





Ч. БАЯРБАТ: ЗЭРЛЭГ АМЬТАН, МАЛЫН БЭЛЧЭЭР ДАВХЦАЖ БАЙНА

ГИДЦГ-ын дарга Ч. Баярбаттай ярилцлаа.

ГИДЦГ-ын талаар товч танилцуулна уу?

ГИДЦГ-ыг 1975 онд улсын тусгай хамгаалалтад авсан. Манай ДЦГ нь "А", "Б" гэсэн хоёр хэсэгтэй. Газар нутгийнхаа хэмжээ (4,633,300 га)-ээр Монгол Улсдаа нэгдүгээрт, дэлхий дээр 15 дугаарт ордог улсын тусгай хамгаалалтай газар (УТХГ) юм. Уг нутагт хавтгай, мазаалай, хулан гэх мэт Төв Ази болон дэлхий дээр ховор тохиолдох олон амьтан бий. Манай хамгаалалтын захиргаанд 30 хүн ажилладаг. Бид Алтайн өвөр говийн өвөрмөц экосистем, олон зүйлийн амьтан, ургамлыг хамгаалах үндсэн үүрэгтэй. Түүнчлэн байгаль дээр өсгөж үржүүлж, олон нийтэд танин мэдүүлж, орчны бүсийн тогтвортой хөгжлийг хангах зорилготой. Манай бүс Говь-Алтай аймгийн Цогт, Эрдэнэ, Алтай, Баянхонгор аймгийн Баян-Өндөр,

Шинэжинст зэрэг сумын нутагт багтдаг.

Энэ бүс нутагт зэрлэг амьтанд тулгарч буй бэрхшээл юу вэ?

Энэ бүс нутагт Монгол орны хур тунадасны дунджаас дөрөв дахин бага хур тунадас ордог учраас усны хүрэлцээ муу. Ирэх дөрөвдүгээр сард Говь-Алтай аймгийн байгаль орчны газартай хамтран уст цэгийн тооллого гүйцэтгэхээр төлөвлөж байна. Ингэснээр хатаж ширгэсэн болон эргэж сэргэсэн булаг, шандны тоог баттай гаргаж чадна. Өнгөрсөн жил ЛАСН-ийн дэмжлэгээр ажиглалтын байртай усалгааны байгууламжийг барьсан. Энэ нь хавтгай болон зэрлэг амьтдад чухал ач холбогдолтой ажил болсон. Дашрамд хэлэхэд, бид ЛАСН-тэй хамтарсан чадавхжуулах



сургалтад манай албан хаагчдын 40 хувь хамрагдсан. Автомат камерын тусламжтай хавтгайн шилжилт хөдөлгөөн, тоо толгой, тархац нутгийг тодорхойлох зорилготойгоор хамтран ажиллаж байна. Энэ судалгааны тайлан мэдээллийг үндэслэн цаашдын хамгааллын арга хэмжээнд анхааран ажиллана.

ГИДЦГ-ын орчны бүсийн иргэдийн байгаль хамгаалалд хандах хандлага ямар байдаг вэ?

Сүүлийн гурван жил Баянхонгор, Говь-Алтай аймгийн орчны бүсийн сумдад гантай байгаатай холбогдон УТХГ-ын хязгаарлалтын бүсэд өвөлжих малчдын тоо нэмэгдэж байна. Малчид хамгаалалтын захиргаанаас зөвшөөрөл авч хязгаарлалтын бүсийн заасан нутагт өвөлждөг болсон. Зааснаас бусад газарт малаа дураар бэлчээх зөрчил гардаггүй. ДЦГ-ын гурван цэгт зэрлэг амьтан, малын давхцал өндөр байна. Бид ЛАСН-тэй хамтран орчны бүсийн таван сумын нутагт анх удаа Хамтын менежментийн зөвлөл байгуулсан. Энэ хүрээнд бүх сумын удирдлага болон байгаль орчны чиглэлээр ажилладаг төрийн албан хаагч, малчин иргэдийн нөхөрлөл, хилийн цэргийн ангийнханд гурван удаа сургалт зохион байгуулсан нь үр дүнтэй ажил болсон гэж боддог. Уг зөвлөл нь менежментийн төлөвлөгөө боловсруулж баталснаар хавтгай хамгаалах үйл ажиллагаа бодитоор хэрэгжиж эхэлсэн.

Бэсрэг буюу эрлийз тэмээний талаар та ямар байр суурьтай байна вэ?

Хавтгай болон гэрийн тэмээний эрлийз томоохон асуудал болдог. 2018 онд орчны бүс болон Өмнөговь аймагт нийт 250 орчим тоо толгой байна гэж тоолсон. Сүүлийн жилүүдэд тэмээний баярыг өргөн хүрээнд тэмдэглэж тэмээг уралдуулдаг болсноор зориудаар бэсрэг тэмээ гаргах хандлагатай. Энэ талаар төрийн бодлого, тодорхой хууль тогтоомж байдаггүй учир бид чадлынхаа хүрээнд малчдад ухуулга сурталчилгаа хийж аль болох тоо толгойг багасгах байр суурьтай байдаг. Алтай сум ямар ч бэсрэг тэмээгүй бол Баян-Өндөр сум маш олон эрлийз тэмээтэй.

ГИДЦГ-т хууль бус агнуур, гар аргаар алт олборлох зэрэг зөрчил хэр гардаг вэ?

Манай УТХГ-ын орчны бүсэд хайгуулын арваад лиценз байдаг. Ашиглалтын тусгай зөвшөөрөл аваад үйл ажиллагаагаа эхлүүлсэн ААН одоогоор байхгүй. Сүүлийн таван жилийн хугацаанд хууль бус агнуурын зөрчил гараагүй. Яагаад гэвэл дархан газрын хамгаалалтын бүс руу орж ан авлахад цаг агаарын хүнд нөхцөлтэй, хол зам туулдаг. Харин орчны бүсэд зээр дайрч авлах тохиолдол мэр сэр гардаг. Хамгийн том асуудал бол хууль бусаар алт олборлогчдын зөрчил учраас эргүүл, хяналтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. 2020 оны байдлаар 100 орчим зөрчил илрүүлж, шийдвэрлүүлсэн.

ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДАА

Монгол Улс нь дэлхийн зэрлэг амьтны хууль бус худалдааны урсгалд аль хэдийнэ оржээ.

Зэрлэг амьтны худалдааны хөгжил динамикийг илүү сайтар ойлгож судлах нь энэ хүрээнд Монгол Улсын гүйцэтгэх үүргийг тодорхойлох, улмаар зэрлэг амьтны худалдааны зах зээлийн нуугдмал, зохицуулалт муутай, эмзэг өртөмтгий байдлыг нарийвчлан авч үзэх эхлэл болох юм. Зэрлэг амьтны худалдаа нь Монгол Улсын дотоодын зах зээлийн нэг чухал салбар хэдий ч 2005, 2015 онд тус тус гүйцэтгэсэн Зэлүүд тал судалгаагаар зэрлэг амьтныг олон улсын зах зээлд шууд ба шууд бусаар нийлүүлж буйг тогтоосон байна. Энэ талаар гүйцэтгэж буй ЛАСН-ийн сүүлийн гурван жилийн ажлыг дараах бүлэгт танилцуулж байна.

ЗЭРЛЭГ АМЬТАД АВРАЛ ЭРЖ БАЙНА

Дэлхий дахинд хар тамхины дараа ордог амьтны эд эрхтний хууль бус худалдаа манай улсад хэдийнэ цэцэглэн хөгжиж, томоохон зах зээл болжээ.



Байгаль орчны доройтол, хүнс тэжээлийн хомсдол, хүний буруутай үйл ажиллагаа, ялангуяа хууль бус агнуураас үүдэн Монгол нутагт төдийгүй цэнхэр дэлхийд хосгүйд тооцогддог амьтад цөөрөн хорогдсоор байгаа нь даан ч харамсмаар. Хуульгүй мэт аашилдаг, буу барьсан цэвдэг сэтгэлтнүүд Монгол орны зэрлэг амьтдыг хайр найргүй хядаж, хүн төрөлхтний өмнө нөхөж баршгүй гарз хохирол учруулж байна.

Дэлхий дахинд хор хөнөөлөөрөө хар тамхины дараа ордог амьтны эд эрхтний хууль бус худалдаа манай улсад хэдийнэ цэцэглэн хөгжиж, томоохон зах зээл болжээ. Энэ хядлага зөвхөн Монгол орны ховор, нэн ховор амьтад гэлтгүй элбэг гэж яригддаг тарвага, цагаан зээр, саарал чонын сүргийг дайрч, улаан зам татуулсаар байна. Ангийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хууль бус худалдаа, эдгэшгүй өвчнийг анагаах чадалтай гэх ам дамжсан хоосон яриа, мухар сүсэг, ашиг хонжоо хайсан хулгайн анчид, дамлан наймаалагчдын шуналын золиос нь хүн төрөлхтөнд хэдхэн үлдээд буй зэрлэг амьтад болжээ. Монгол хүн бүрийн өмөөрөн хайрлах учиртай амьд байгаль сүйрлийн ирмэгт тулж

ирээд байна.

Хүн төрөлхтнөөс аврал эрж буй Монголын зэрлэг амьтдыг хайрлан хамгаалах ажлыг ЛАСН эхлүүлээд цөөнгүй жилийг үдэж байгаа юм. Тус нийгэмлэг нь ИБУИНВУ-ын Байгаль орчин, загас агнуур, хөдөө аж ахуйн яамны харьяа Зэрлэг амьтны хууль бус худалдааны сорилтын сангийн санхүүжилтээр Лийгэл Атлас болон Монголын Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран “Зэлүүд тал” судалгааг хоёр удаа гүйцэтгэв.

Анх “Зэлүүд тал I” тайланг одоогоос арав гаруй жилийн өмнө буюу 2006 онд хэвлүүлэхэд Монгол Улс зэрлэг амьтдын хямралт байдалд оржээ гэсэн дүгнэлтэд хүрчээ. Зэрлэг амьтны хууль бус худалдаа нь олон сая ам.доллараар хэмжигдсэн томоохон бизнес болтлоо өргөжсөн нь харагдсан байна.

Харин 2016 онд хэвлүүлсэн “Зэлүүд тал II” тайлан нь энэхүү хямралт байдал үргэлжилсээр буйг сануулжээ. Арван жилийн зайтай гүйцэтгэсэн хоёрдахь судалгаагаар Монгол Улсад зэрлэг амьтдын хямрал үргэлжилсээр буй нь нотлогдлоо. Товчхондоо, Монгол нутагт оршин буй зэрлэг амьтад манай төр засаг, олон нийт,

холбогдох байгууллагуудаас амь тавин аврал эрсээр байна.

Тэгвэл амин чухал энэ ажлыг ЛАСН цаг алдалгүй эхлүүлж, Монгол орны зэрлэг амьтдын тоо толгойг хамгаалахаар ханцуй шамлан ажиллаж байна.

Монгол бол 1.5 сая хавтгай дөрвөлжин газар нутгийг эзлэн оршдог цэлгэр уудам нутаг. Хилийн нийт урт нь 8.2 мянган км сунан үргэлжилдэг. Ийм өргөн уудам нутагт тархсан зэрлэг амьтныг хамгаалах нь өвснөөс зүү эрэхтэй ижил амаргүй ажил. Гэтэл боловсон хүчний чадавх сайнгүй, цомхон бүтэцтэй, техник тоног төхөөрөмжийн хувьд сул Монгол Улс хайрлан хамгаалах учиртай амьтаддаа анхаарал тавьж чадалгүй, ашиг хонжоо хайгчдад алдсаар.

Дэлхийн зэрлэг амьтны хууль бус худалдааны томоохон зах зээлүүдийн нэг Хятад улс руу зорчих хил орчмын иргэд гэмт хэрэг зөрчил, тэр дундаа зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн хууль бусаар тээвэрлэн өөрсдийгөө эрсдэлд оруулсан тохиолдол цөөнгүй байна. Үүнд иргэдийн хууль тогтоомжийн мэдлэг дутуу, төрийн байгууллагад мэдээлдэггүй, холбогдох албаныхантай хамтран ажилладаггүй зэрэг дутагдлууд илэрч байгаа юм. Ялангуяа, хээр тал нутгийн жинхэнэ хамгаалагчид болох малчдын энэ төрлийн хуулийн мэдлэг тун хомс байгаа нь хууль бус агнуур хяналтаас гарах гол шалтгаан болж байна.

Иймд ЛАСН нь Монгол Улсын зүүн болоод өмнөд хилийн гурван шалган нэвтрүүлэх боомтыг (Дорноговь аймгийн Замын –Үүд сумын Замын-Үүд, тус аймгийн Хатанбулаг сумын Ханги, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт боомт) сонгон авч 2018 оноос төсөл хэрэгжүүлж эхэлжээ. Эдгээр боомтын хяналтыг сайжруулахын тулд Гаалийн ерөнхий газрын эрэлч нохойн сургалтын төв болон зорилтот боомтуудад үүрэг гүйцэтгэж буй эрэлч нохойтой гаалийн улсын байцаагчдыг чадавхжуулах зорилгоор Их Британийн Хилийн албаны мэргэжилтнүүдийг урьж сургалтын хөтөлбөр, сургалтын байр, нохойнуудад үнэлгээ хийлгэсэн байна. Энэ нь гадаадын мэргэжилтнүүдээс туршлага судалсан анхны тохиолдол болсноороо онцлог аж. Түүнчлэн үнэлгээнээс гарсан зөвлөмжийн дагуу ГЕГ-ын

эрэлч нохойн сургалтын төвийн засвар тохижилт, сургалтын материаллаг баазыг шинэчлэн ноходод шинэ үүр барьж өгчээ.

ЛАСН хил гаалийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлээд зогсоогүй. Хууль бус худалдаатай тэмцэхэд хувь нэмрээ оруулах учиртай хил орчмын иргэдийг энэ ажилд татан оролцуулж эхэлжээ. Үүний тулд орон нутгийн удирдлагуудтай гэрээ байгуулж, олон нийтийн таван цагдааг ахлах алба хаагчдын хамт сурган, гурван жилийн турш цалин, хувцас хэрэглэл болон олон нийтэд таниулан

сурталчлах материалаар хангаж ажиллаж байна.

Ингэснээр цагдаагийн алба хаагчдын зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн, амьтны зүйл, тээвэрлэх нуух арга замууд, холбогдох хууль тогтоомж, хүний эрх, хүн худалдаалах гэмт хэрэг, нотлох баримт цуглуулах арга зүй зэргийн талаарх мэдлэг нэмэгджээ. Давхардсан тоогоор 380 аж ахуйн нэгжид ухуулга

сурталчилгаа хийж, мэдээллээр хангаснаар хил орчмын иргэдийн энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголт мэдлэг сайжирчээ.

Зэрлэг амьтан, ургамлын хууль бус агнуур, худалдааг бууруулах, таслан зогсооход олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус ажилтнуудад туслах зорилгоор гар утасны “Соргог” аппликейшнийг ИБУИНВУ-ын Засгын газрын дэмжлэгээр бүтээсэн нь Монгол Улсын гааль болон цагдаагийн байгууллагын ашигладаг үндсэн гарын авлагын нэг болжээ.


Ийнхүү ЛАСН аврал эрсэн зэрлэг амьтдыг хамгаалах ажлыг бодитой эхлүүлж, үр дүнтэй үргэлжлүүлж байна. Харин бидний оршин буй орчны тэнцвэрийг хангагч, байгалийн нэгээхэн хэсэг болох амьд байгалийг ашиг хонжоо хайгчдаас хамгаалахад иргэдийн оролцоо, эх дэлхийдээ элэгтэй монгол түмний идэвх сэтгэл чухал байна.

3
ЛАСН нь Монгол Улсын гурван боомтод зэрлэг амьтны хууль бус худалдааг зогсоох төсөл хэрэгжүүлж байна.

ЗЭЛҮҮД ТАЛ ТАЙЛАН
Арван жилийн хугацаатай гүйцэтгэсэн хоёр ч судалгаагаар Монгол Улсад зэрлэг амьтдын хямрал нүүрлэсэн нь дахин нотлогдлоо.



Монголд 250 мянган анчин бий. 70 сая малтай манай улсын анчны тоо 2005 оноос хойш буураагүйгээс гадна, залуу анчин олон байна.



Нийт 70 мянга орчим загасчин бий. Энэ тоо нэмэгдэх хандлагатай. Нэг загасчны барих загасны зүйл төрөлжиж, тоо хэмжээ нь өссөн.



Монголд хамгийн их авладаг ан. 2015 онд л гэхэд 849,764 тарвага агнажээ.

250k
850k

Монгол Улс

АН АГН УУР

ЗЭЛҮҮД ТАЛ II

26%

43

70k


44k



Манай улсад 44 мянган чонын анчин бий. Тэд квотоос бараг мянга дахин давуулан авлаж байна.



Ан авлах уламжлалт ёс зөрчигдөж байна. Амьтныг эцтэл хөөх, гэрэлтүүлж буудах зэрэг хэрцгий аргууд 2005 оны судалгаагаар илрээгүй.



2005 онд 34 төрлийн ан авласан бол 10 жилийн дараа 24 болж буурав. Ховор амьтан авласнаа нуун асуултад хариулахаас татгалзаж байсан нь анчдын эрхзүйн мэдлэг нэмэгдсэнтэй холбоотой.



Б.НАРАНБАДРАХ: НОХОЙ БОЛ ҮНЭРЛЭХ МЭДРЭМЖ САЙТАЙ АМЬД ҮНЭРИЙН АППАРАТ

Б. Наранбадрах нь Гаалийн ерөнхий газар (ГЕГ)-ын Эрэлч нохойн сургалтын төвийн дарга албан тушаалтай. Хил гаалийн 11 боомт дээр нийт 34 эрэлч нохойн байцаагчийг хариуцаж ажилладаг. Гол зорилго нь улсын хилээр хориглосон буюу хязгаарласан бараа бүтээгдэхүүнийг орж, гарахад нь олж илрүүлэхэд эрэлч нохойг сургаж, хил гаалийн боомтуудад ажиллуулах юм.

Монгол Улсад эрэлч нохойг хэзээнээс гааль дээр ажиллуулж эхэлсэн бэ?

Түүх яривал Хил хамгаалах ерөнхий газрын Лүнгийн нохойн сургуулиас улбаатай. Одоогоос 80-аад жилийн өмнө үүссэн. ГЕГ-ын хувьд анх 1993 онд Эрэлч нохойн сургалтын тасаг нэртэй долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулж байсан. Миний бие 1997 оноос уг байгууллагатай амьдралаа холбож сургалт хариуцсан багшаар ажиллаж байгаад 2006 онд албаны дарга болсон. Манай төв нь Брюссель дэх Дэлхийн гаалийн байгууллагатай хамтран ажилладаг. Казахстан, Узбекистан, Азербайжан зэрэг улсад голчлон хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гурван сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцдог. Миний хувьд хоёр удаа буюу 1997, 2005 онд Япон улсад зохион байгуулсан хар тамхи, мансууруулах бодис, хориглосон, хязгаарласан бараа бүтээгдэхүүн олж илрүүлэх нохойн сургагч багш гэсэн мэргэжлээр төгссөн.

Эрэлч нохой болон түүний сургагчийг олон болгох тал дээр манай улсад ямар ажил хийж байна вэ?

Эрэлч нохойн байцаагчийн хувьд халуун, хүйтэн цаг агаарын ямар ч нөхцөлд гадаа ажилладаг ч цалин бага учраас шавь нар маань шантрах тохиолдол олон гардаг. Сүүлийн жилүүдэд



ЛАСН-ээс хэрэгжүүлж буй хөтөлбөр манай хамт олон маш том хөшүүрэг болж байгаа. Жил бүр шалгаруулах "Амьд байгалийн хамгаалагч" хэмээх нэр хүндтэй шагналыг авахын тулд зэрлэг амьтан, ургамлын эд эрхтэнг илрүүлэхийн төлөө уйгагүй ажиллаж байна. Манай нэг шавь тус нийгэмлэгийн зардлаар Лондон руу туршлага судлаад ирсэн. Ер нь сургагч бэлтгэхээс илүүтэй сайн эрэлч нохой олох хэцүү. Монгол Улсад үржил, селекцийн үйл ажиллагаа явуулдаг хувийн байгууллагууд байдаг ч мэргэжлийн шаардлага хангасан албаны үүлдрийн ноход цөөхөн. Эдгээрийг олж

авахын тулд олон арга ашиглаж байна. Заримдаа гадаадын донор орноос бэлгэнд авна. Зарим үед худалдан авна. Ер нь нохой эволюцын хуулиар байнга өөрчлөгдөж байдаг. Урьд Орос овчарк сайн гэж үздэг байлаа. Дараа нь Немц овчарк болсон. Тэгээд лабрадор, голден ретривер, спаниель гэх мэт нохойн хөгжил маш хурдтай өөрчлөгдөж явсаар өнөөдөр Белги овчарк боллоо. Энэ нь Малиной үүлдрийн нохой. Бусад нохойг бодвол

хурдан сурдаг, үнэрийг удаан мартдаг, ажлын ачаалал сайн даадаг. Немц овчарк өдөрт найман цаг ажилладаг бол энэ нохой 17 цаг тасралтгүй ажиллах чадвартай. Бусад нохой найман жил ажиллаж тэтгэвэртэй гардаг бол Малиной түүнээс хоёр дахин илүү. Энэ үүлдрээс бид 2015 онд эр, эм хоёр нохойг Азербайжан улсаас оруулж ирээд эх орондоо нутагшуулах болон үржил селекцийн ажлыг сүүлийн хоёр жил зохион байгуулж байна. Энэ хугацаанд төл авч, тэдгээрийг сургаад хилийн боомтууд руу илгээж, мөн бусад төстэй үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагад бэлгэнд өгсөн.

34
Монгол Улсын
хил, гаалийн
байгууллагад
ажилладаг бүх эрэлч
нохой тоо ердөө
34 байдаг.

Малиной ноход одоо хэдүүлээ болсон бэ?

Эхний төрөлтөөр зургаан гөлөг гарснаас хоёр хоёроор нь өөрсдөдөө болон цагдаад, хилийн цэрэгт хуваасан. Сүүлийн төрөлтөөс бас зургаан гөлөг гарсан. Тэгэхээр бидэнд нийт найман нохой байгаа гэсэн үг. Одоо хаврын төрөлтийг хүлээж байна. Нохой бол хавар, намартаа буюу зургаан сар болоод гөлөглөдөг амьтан.

Тэд одоо 34 эрэлч нохойд дэм болох нь дээ?

Үнэндээ 34 нохой хаана ч хүрдэггүй. Тэднийг олшруулах нь чухал. Сүүлийн хоёр жил Ковид-19 гээд хил хаасан ч бид түүвэр ачаанд шалгалт хийсээр байгаа. Тухайлбал, гадаадаас ирсэн дөчин тонны чингэлэгт байгаа юу нь мэдэхгүй түмэн ачаанд нохойгоор үнэртүүлж үзлэг, шалгалт хийнэ. Үүнд, буу, сум, хар тамхи гэх мэт ямар ч хориотой бараа байж болно. Тиймээс нохой ачаалалтай ажиллаж, их ядардаг. Зөвхөн Малинойд найдаж бас болохгүй. Жишээ нь, Баян-Өлгий өндөр уулс ихтэй бол Замын Үүд элстэй халуун газар учраас цаг уурын нөхцөлийг даахгүй. Түүний үс тачирхан, бие жижиг. Иймд цаг ууртай уялдуулж нохдоо бэлдэх ёстой. Нохой бүр өөрийн онцлогтой. Улаанбаатарын нөхцөлд бид гурван төрлийн нохой ашиглаж байна. Немц овчарк, малиной, спаниель.

Зэрлэг амьтны эд эрхтэнг хил дамжуулан тээвэрлэх хэрэг хэр зэрэг гардаг вэ?

Ер нь илрүүлэхээс илүү урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь хамгийн чухал гэж би боддог. Ялангуяа хүүхэд, залууст зэрлэг амьтны ач тус, экологийн тэнцвэрт байдлын талаар ойлгуулж, сурталчлах ёстой. Тэгснээр алж устгасны дараа биш өмнө нь арга хэмжээ авч чадна. Ийм учраас бид Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад холбогдох байгууллагуудтай хамтарч ан авлаж явахад нь нохойгоор илрүүлж, зогсоох ажлыг сүүлийн хоёр жил гаруй хугацаанд зохион байгуулж байна. Түүнээс гадна, гадаадаас ирж байгаа буу, сумыг заавал олохын төлөө бид ажиллаж байгаа. Хэрэв тэгж чадвал, устгал хийж чадахгүй. Хамгийн сүүлийн жишээ гэвэл өнгөрсөн онд ЛАСН-тэй хамтарч ажилласны дараа бид 49 мянган сум илрүүлсэн. Энэ хэмжээний сумаар алдаж буудлаа гэхэд 20 мянган ан авлана шүү дээ.

Тарваганы арьс их хэмжээгээр хил давуулах оролдлогыг таслан зогсоосны төлөө таны биед

халдсан хэрэг гарч байсан. Энэ мэт халдлага олон гардаг уу?

Байцаагчийн бие болон эрэлч нохойд халдах оролдлого их гарна аа. Тэр үед би Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт байцаагчаар ажиллаж байлаа.

Улсын хилээр тарваганы арьсыг байсхийгээд л гаргах гэж оролддог байсан. Нэг удаа 17 мянган тарваганы арьс гаргах гэж байсныг илрүүлсэн. Нохойгоор илрүүлээд байхаар нохойг юм уу эсвэл эзнийг устгах ажлыг ашиг хонжооны төлөө улайрсан хүмүүс зохион байгуулдгийн нэг жишээ. Тэр үед би хоолойгоо огтлуулж хоёр удаа хутгалуулсан. Байр саваа зараад, эсвэл хүнээс мөнгө зээлээд түүгээрээ тарваганы арьс аваад хууль бусаар хилээр нэвтрүүлэх гэж байгаа хэсэг

нөхөд гэрчийг устгана гэдэг шиг намайг устгах гэж оролдсон. Ингэж чадвал тэд бараагаа хил давуулж арвин мөнгөтэй болно гэж ойлгосон байх. Гэвч ганцхан би биш, надтай хамт гаалийн бүхэл бүтэн бие бүрэлдэхүүн ажилладаг гэдгийг ойлгох ёстой. Нохой нь амьтны эд эрхтэнг төвөггүй олдог. Тухайлбал, бугын чив, баавгайн доньт, сарвуу, чонын арьс, шонхор мэт ховор шувуудыг байгалийн зөнгөөрөө маш хурдан илрүүлдэг. Юуг нь мэдэхгүй ороосон эд зүйлсийг рентген аппарат илрүүлж чадахгүй байхад нохой оролдоод салдаггүй. Нэг тохиолдлын тухай ярихад хүн харахад хоосон усны савуудыг хилээр гаргах гэж байгаа мэт харагдсан. Гэтэл нохой оролдоод салахгүй байсан. Задлаад үзтэл шонхор шувууд байв. Гэтэл энэ шувуу чинь ховордсон шүү дээ. Тэд ховордсоноор идэш тэжээл нь болдог үлийн цагаан оготно өсөж байна. Энэ шувууг зарлаа гээд Монгол Улсад тийм их мөнгө ордоггүй, зарж борлуулахаа болих ёстой гэж би боддог доо.

Ер нь ямар зүйлийн амьтныг хамгийн их хил нэвтрүүлэхийг завддаг вэ?

Би өөрөө үндэсний аюулгүй байдлын төлөө ажилладаг хүн.

Миний бодлоор аль нэг гадны улс бодлогоор Монголын зэрлэг амьтныг устгуулж байна гэж харддаг. Үүнийг эх орноо гэх сэтгэлгүй цөөхөн хэдэн цаасанд толгойгоо мэдүүлсэн сувдаг сэтгэлтэй нөхөд ойлгохгүй хамаг амьтнаа гадагшаа зөөж байна. Эх орны экологийн тэнцвэр алдагдах нь тэдэнд ямар ч хамаагүй. Би нэг жишээ ярья. Тэмээн тавхай авна гэж хэдэн зуун мянган тэмээ устгуулсан. Тэмээн тавхай үнэд ороод Хятад руу зөөгөөд л байсан. Үнэхээр эм тариа хийдэг юм болов уу гээд чих тавиад үзтэл яг үнэндээ тэнд бөөгнүүлээд шатаасан байсан. Энэ нь Монголыг тэмээгүй болгох бодлого байж гэж



ойлгосон. Тэмээтэй орон ямар байх вэ, бодоод үз дээ. Энэ мэтээр олон жишээ бий. Адууны дэл, сүүл, хонины өлөн. Үнэндээ, Хятадууд өөрсдөө малгүй улс биш шүү дээ. Баавгай авъя гэхгүй, тэд чинь. Баавгайн доньт, сарвуу, соёо авна гээд ханасан үнэ зарлачихна. Түүгээр яг юу хийдэг вэ. Би л хорь гаруй жил ажиллахдаа Монголоос авсан баавгайн сарвуугаар дэлхий дээр эмийн бүтээгдэхүүн хийлээ гэж сонсоогүй. Үүнийг үндэсний аюулгүй байдлынхаа төлөө хүн бүр санаж явах ёстой. Хууль бусаар хил дамжуулах оролдлогыг олж илрүүлээд эзэн холбогдогчид нь хариуцлага хүлээлгэдэг. Үнэндээ, монгол хүнээ шоронд оруулах нь бидний хүсэл биш. Иймд, ховор амьтдын байгальд үзүүлэх ашиг тусыг сурталчилж, устаж үгүй болбол юу болох талаар мэдээлэл түгээх нь хамгийн чухал гэдгийг дахин сануулъя. Жишээлбэл, чоныг маш ихээр устгаж байна. Гэтэл чоно байгальдаа цэвэрлэгч хийж байдаг. Чоно уствал энэ байгаль чинь сэг зэмээр дүүрнэ. Түүний гөрөөл амьтад өвчин эмгэг тусна, тэгснээр бас л ховордоно. Түүнийг элдэж хөөгөөд, устгаад хүний хийморь сэргэхгүй гэдгийг хүүхдэд багаас нь ойлгуулах ёстой. Зэрлэг амьтны талаар комик ном Японд олон байдаг. Тэнд хүүхдүүд багаасаа зэрлэг амьтны ач тусын талаар суралцан өсөж байна. Монголд ийм ном гаргаасай гэж их боддог. Зөвхөн зэрлэг амьтан гэлтгүй эрэлч нохдын талаар ч сурталчилмаар байна. Жишээ нь, жижигхэн хөөрхөн гөлөг улсын хилээр орж ирээд монголчуудад ямар их ач тус хүргэсэн талаар комик ном хийж болно.

99%
Бидний сургалтын гол зарчим бол 1% нохой, үлдсэн 99%-д сургагч ажиллах ёстой гэж үздэг.

Яг ийм түүхтэй эрэлч нохой олон байх. Та нэг сонирхолтой түүх хуваалцвал?

Галья гээд хөөрхөн спаниель гөлгийг бид Азербайжан улсаас 2002 онд авчраад Монголын хатуу ширүүн цаг уурын нөхцөлд дасгаж, дотоодын сургалтад хамруулаад, Замын-Үүдийн боомт руу ажилд томилоод явуулсан. Галья очоод жил орчим ажилласны дараа нэг шөнө манай ажилтан над руу залгаад “Дарга аа, галт тэрэг дотор дөрвөн хятад иргэн байна. Тэд олон төрлийн жимс, ногоог ширээн дээрээ задлаад тавьчихаж. Тэр дундаас Галья нэг шилтэй ногоог сонирхоод байна. Таны яриад байдаг буурцаг хэлбэрийн хар тамхины ургамал шиг байна. Эд нар хүнсний ургамал гээд байна” хэмээн ярьсан. Хариуд нь би маш их зүсэгдсэн, мөчир нь хоёр мм хэмжээтэй жижиг байх ёстой гэх мэт шинж чанаруудыг асуутал яг таарав. “За тэгвэл, эзэн холбогдогчийг саатуулах газарт хүлээлгэн өгөөд наад ургамлаа аваад Галья та хоёр шууд наашаа хот руу шөнийн галт тэргээр хүрээд ир” гэлээ. Өглөө ирэнгүүт бид өнөөх шилтэй ургамлыг лабораторийн шинжилгээнд оруултал манай улсад таван га талбайд тариалах хар тамхины ургамлын үр байв. Энэ хэмжээний талбайд тарьсан бол манай улсад их л гай авчрах байлаа. Гэтэл Галья маань урьдчилан мэдэж таслан зогсоосон байдаг. Энэ мэт гавьяа байгуулсан нохой олон. Астра гэж нохой байсан. Миний Астра бол зөндөө хэрэг илрүүлсэн дээ. Даан ч Сэлэнгэ аймагт ажиллаж байхад хүйтэн сэтгэлтнүүд хоолонд нь хор хийн хөнөөсөн. Намайг хутгалаад дийлэхгүй болохоор нохойг маань хороосон.



Нохойгоо алдсаны дараа дахиад нохой сургахад маш их хугацаа алддаг. Тэр хооронд ямар ч бараа хил давахыг мэдэхгүй. Манай нэг нохой Баян-Өлгийд ёстой л улаан хөлтийг урдуураа гаргадаггүй байлаа. Жолооч нарын нуусан бүхнийг илрүүлдэг. Нэг өдөр нохой маань гудмаар явж байтал дайрч алсан. Энэ мэтээр таван нохой алдсан даа.

Үүний адилаар зэрлэг амьтантай холбоотой зөрчил илрүүлсэн түүх олон уу?

Зөндөө байгаа. Хяналтын ажилтан цөөнтэй, Шивээ хүрэн, Гашуун Сухайт зэрэг боомтод ийм зөрчил олон гардаг. Замын-Үүдэд хяналтын маш том аппарат ажилладаг учраас зэрлэг амьтан гаргаж зориглохгүй. Мэр сэр гарвал шууд таслан зогсоодог. Дээрх хоёр боомтоор нүүрс тээвэрлэлт голдуу гардаг учраас зэрлэг амьтны эд эрхтэнг нүүрсний доор нуух нь элбэг. Овор багатай эд зүйлс нүүрсэн дор байвал рентген аппарат илрүүлж чадахгүй. Харин нохой машины дээгүүр, доогуур оролдоод байвал нарийвчилсан үзлэгт заавал оруулдаг. Тэнд олон зүйлийн ховордсон амьтны эд эрхтэнг маш нарийн боож, баглан нуусан байдаг. Түүнчлэн Хятадын жолооч нараас “мими” хэмээх бодис их илэрнэ. Өөрсдөө мансуурсан учраас юу авч яваагаа мэддэггүй. Энэ бодис нь хүнийг 72 цаг унтахгүй байлгаж, сэтгэцэд нөлөөлдөг. Сүүлийн үед урьдчилан сэргийлэх ажил их хийж



байгаа учраас зэрлэг амьтны эд эрхтэнг тээвэрлэх зөрчил харьцангуй багасаж байна. Гэхдээ асар их баялагтай манай улсаас алт, зэс, эрдэнийн чулуу зэрэг олон зүйлийг хууль бусаар гаргах оролдлого их гарна. Энэ бүгдийг нохой илрүүлж чадна. Тухайлбал, УАЗ 469 маркийн машины эд ангид гулууз алт нуугаад хил давуулах гэж байсныг манай нэг нохой илрүүлсэн. Хүмүүс нохой алт үнэрлэх үү гэж асуудаг. Нохой бол өдөрт олон мянган үнэрийг үнэртээд дассан байдаг. Тэд машинаас юу үнэртдэгийг аль хэдийн мэдэж байгаа. Иймээс машины хамар дотор гаднын нэг биет байгааг үнэрээр мэднэ. Бид бол мэдэхгүй, харин нохой хүнээс долоон мянга дахин илүү үнэр мэдрэх чадвартай амьд үнэр мэдрэгч аппарат юм. Нохой алдана гэж үгүй. Гол нь сургагч түүнийг мэдрэх ёстой. Бидний сургалтын гол зарчим бол 1 хувь нохой, үлдсэн 99 хувьд сургагч ажиллах ёстой гэж үздэг. Нэг удаа, бид оёдлын үйлдвэрлэлтэй холбоотой өрөөд тавьсан маш олон хайрцаг дунд шалгалт хийж явтал найм дахь давхаргын хайрцаг руу нохой үсрээд салахгүй байсан. Задлаад үзтэл маш их хэмжээний бэлэн мөнгө байв. Ингэж мөнгө угаах гэмт хэргээс сэргийлж байлаа. Бидний хувьд нэг ширхэг өд ч эх орны минь үнэлшгүй баялаг, маш их үнэ цэнтэй эд. Нэг муу соёо авахын төлөө амьтны амь егүүтгэх нь учир утгагүй санагддаг. Тэгээд ч тийм өндөр үнэд хүрдэггүй шүү дээ.



Я. МӨНХНАСАН: АМИЛЖ БОСООД ОНГОН БАЙГАЛЬДАА ЭРГЭН ОЧООСОЙ ГЭЖ БОДДОГ

Эрэлч нохойтой байцаагч нарын гүйцэтгэлийг үнэлж урамшуулах Английн туршлагыг Монголд нэвтрүүлэх ЛАСН-ийн ажлын эхлэл болсон “Зэрлэг амьтны хамгаалагч” шагналын эзэн Я. Мөнхнасантай ярилцлаа. Тэрээр 2007 онд Гаалийн эдийн засгийн дээд сургуулийг төгсөөд Замын-Үүд дэх Гаалийн газарт эрэлч нохой хариуцсан улсын байцаагчаар томилогдож арваад жил ажиллажээ. Энэ хугацаанд эрэлч нохойн тусламжтай 290 гаруй хэрэг зөрчил илрүүлсэн байна. Одоогоор Гаалийн ерөнхий газар (ГЕГ)-ын Эрэлч нохойн сургалтын төвд ажилладаг.

Замын-Үүдэд ажилласан тухай яриагаа эхлэх үү?

Тус боомтод 2007-2015 он хүртэл ажилласан. 2015 оноос Улаанбаатар хотын Гаалийн газар, Буянт-Ухаа дахь Гаалийн газарт ажиллаж байгаад эргээд 2017-2019 он хүртэл Замын-Үүд дэх Гаалийн газарт ажилласныг тооцвол нийт арваад жил ажилласан. Замын-Үүд

дэх улсын хилээр ачаалалтай үедээ өдөрт ачааны 300 гаруй, суудлын 900 машин, 3,000 гаруй зорчигч, 30 гаруй зорчигч тээврийн вагон, 2,500 гаруй ачааны вагон зорчдог маш том боомт. Энэ их хөдөлгөөний хаагуур ч хууль бус бараа гарахыг үгүйсгэхгүй. Бид энэ бүгдийг хянаж ажилладаг.

Хилийн цаана байгаа Эрээн хот нь зэрлэг амьтан, ургамлын том зах зээл учраас тус боомтоор тээвэрлэх магадлал өндөр байдаг.

Энэ боомтоор зэрлэг амьтан, ургамлыг хууль бусаар тээвэрлэх зөрчил хэр их гардаг байв?

2015 оноос өмнө ангийн гаралтай бүтээгдэхүүн болох тарвага, үнэг, хярс, чонын арьс гаргах зөрчил их байсан. Шалтгаан нь Эрээн хотод үслэг ан өндөр үнэтэй байв. Харин 2015 оноос хойш ховор амьтны эд эрхтэн, тухайлбал баавгайн сарвуу, соёо, бугын чив зэргийг тээвэрлэх зөрчил илрэх болсон. Жишээ дурдвал, 2019 онд баавгайн соёо биедээ авч яваа зөрчлийг илрүүлсэн. Үүнийг энгийн шалгалтаар илрүүлэх боломжгүй.

96

Замын-Үүд дэх гаалийн байцаагчид 2019 онд 4 бугын сүүл, 3 баавгай соёо, 71 чонын соёо, 18 чонын арьс нийт 96 зөрчил илрүүлсэн.



6 чоно, 6 дугуй: Машины дугуйнд нуусан эд зүйлсийг нохой төвөггүй илрүүлнэ.

Харин нохой байгалийнхаа зөнгөөр илрүүлдэг. Түүнд ямар нэг үнэр үнэртүүлэх шаардлагагүй. Зорчигчийн вагонд нохой маань чөлөөтэй явж байгаад нэг Хятадын иргэний хажууд очоод сонирхож эхэлсэн. Араас нь очоод шалгаж үзтэл олон тооны баавгайн савруу, соёог гадуур хувцсандаа оёж тогтоосон байсан. Замын-Үүд дэх гаалийн байцаагчид 2019 онд бугын дөрвөн сүүл, баавгайн гурван соёо, чонын 71 соёо, 18 чонын гулууз илрүүлсэн.

Зөрчил гаргасан Хятад иргэнд ямар шийтгэл ногдуулсан бэ?

Зэрлэг амьтан, ургамлыг олон улсын хил дамжуулан худалдаалах тухай CITES-ийн конвенц болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу тус иргэнийг саатуулсан. Бид эрүүгийн шинжтэй гэмт хэрэг учраас цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

Нохойн тухай яриандаа орьё. Та ямар үүлдрийн нохойд илүү дуртай вэ?

Нохойн ажиллах хугацаа нь 8-10 жил. Би нийт гурван нохой сольсон. Миний хувьд овчаркад илүү дуртай. Цаг агаарын ямар ч нөхцөлд ажиллах чадвартай, түшигтэй нохой. Замын-Үүдэд 24 цагийн туршид л вагон түчигнээд хонодог. Бүхий л хугацаанд нохой минь хамт ажилладаг. Хүмүүс бол зэрлэг амьтны эд эрхтэнг шөнө эсвэл өдрийн хамгийн ачаалалтай үеэр хил гаргах гэж оролддог. Ийм үед ядрахыг мэддэггүй. Хүмүүс ихэвчлэн өмсөж буй хувцсандаа эсвэл вагоны эд ангид зэрлэг амьтны эд эрхтэнг нуудаг.

Хамгийн хайртай нохойнхоо тухай яривал?

Миний анхны нохойг Хайнт гэдэг байв. Хайнт маань маш их зөрчил илрүүлсэн. Ялангуяа, ангийн

гаралтай зүйлийг “гаргаадаггүй” байв. Дараа нь Жек хэмээх нохойтой болсон.

Хамгийн сүүлд буюу 2019 онд Арлит гэдэг нохойтой ажилласан. Тэдний илрүүлсэн томоохон зөрчлийн тухай яривал?

Нохойг үр дүнтэй ажиллуулахын тулд салхины чиглэлийг сайтар тооцох ёстой. Замын-Үүдийн хувьд Монгол Улсын өмнөд хил дээр байрладаг. Салхины чиглэл ихэнхдээ баруун хойноос байдаг давуу талтай. Хойноос цуварч ирэх машины цувааг тосоод зогсож байхад нохой ямар нэг үнэр мэдэрвэл сортолзоод эхэлдэг. Энэ үед нь нохойтой ярилцаад, түүнийг чиглүүлэх ёстой. Ингээд л цуван зогсох үед нь илрүүлдэг дээ. Биднийг ажиллаж байх хугацаанд 64 чоно авч яваа тохиолдол гарч байсан. Мөн Норд бенз ачааны машины хойд 12 дугуйнд 2,500 гаруй, тэвшинд 1,500 тарваганы арьсыг нохой илрүүлсэн. Нохой салхины чиглэл таарвал 100 метрийн цаанаас мэдэрдэг. Ялангуяа өвлийн улиралд хөлдөөсөн чоно, түүний эд эрхтэн тээвэрлэх нь ихэсдэг. Жижиг тэрэгний дугуйнд нуусан тохиолдол асар их гардаг. Нохой бол машины дугуйг нэг үнэрлээд л мэддэг дээ. Амьтдыг маш олноор нь алсан байхыг хараад үнэхээр харамсдаг. Хэдийгээр би хилээр давахыг зогсоосон ч амилаад төрсөн нутагтаа буцаж очихгүй гэж бодохоор гунигтай байдаг. Байгалийн амьтан байгальдаа л үзэмжтэй. Хэрэв болдог бол амилж босоод онгон байгальдаа буцаад очоосой гэж боддог.


Эрэлч нохойн олон улсын сургалт их болдог гэж сонссон. ЛАСН-ээс зохион байгуулсан

нохой сургалтын талаар та сэтгэгдлээ хуваалцахгүй юу?

Уг сургалт нь нохойн үнэрлэх чадварыг хэрхэн 100 хувь ашиглах талаар заасан. Маш далд нуусан зүйлийг нохойгоор яаж олуулах аргачлалыг заасан маш үр дүнтэй сургалт болсон. Түүнчлэн сургалтын явцад нарийвчлалтай хайх тоног төхөөрөмжөөр хангаж өгсөн нь бидний ажилд өндөр үр дүн өгсөн гэж боддог. Нэгдүгээрт, эргэх хөдөлгөөн дунд үнэрлэж мэдрэх. Хоёрдугаарт, олон нүхтэй тоосгоноос олж илрүүлэх аргыг заасан.

Та бол тус байгууллагаас шалгаруулдаг “Зэрлэг амьтны хамгаалагч” хэмээх шагналын анхны эзэн болсон. Энэ тухайгаа хуваалцвал?

Эрэлч нохой ашиглан зэрлэг амьтан, ургамлын холбогдолтой хамгийн олон зөрчил илрүүлсэн байцаагчид өгдөг шагнал. Би энэ шагналыг авсандаа маш их баяртай байна. Манай залуус энэ шагналыг авахын төлөө уйгагүй ажиллаж байсан боловч хилийн боомтууд хаалттай байгаа учраас сэтгэл гонсгор байв. Гэхдээ энэ жил нохойтойгоо хэн сайн ажиллаж байгааг хөндлөнгийн мэргэжилтнээр шалгуулаад шалгаруулсан гэж сонссон.



Н. ГАНБОЛД,
ГЕГ-ын Эрэлч
нохойн
сургалтын
төвийн
ажилтан

ЛАСН-ийн дэмжлэгээр Англи руу очоод туршлага судлаад ирлээ. Английн нохойн албаны

давуу тал нь хангамж сайтай. Ажилтан бүр албаны машиндаа нохойгоо хажуудаа суулгаад явдаг. Дараа нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Хилийн албаны эрэлч нохойн үндэсний багийн ахлах дасгалжуулагч Роберт Грей Монголд ирж манай албаныханд хоёр долоон хоногийн сургалт зохион байгуулсан. Роберт манай нохойн ур чадвар бусад орныхоос дутах зүйлгүй сайн гэж үнэлсэн. Харин сургалтын аргачлалын хувьд илүү сайжруулах шаардлагатай гэсэн. Тухайлбал, карусель хэмээх төхөөрөмжийг бид уг сургалтын хүрээнд шинээр ашиглаж эхэлсэн. Үр дүнгээ өгч байгаа. Нохойд богино

хугацаанд их хэмжээний давтлага хийх боломж олгох зориулалттай. Өмнө нь цувуулж тавьсан хайрцгийг зөөж тавих механик ажиллагаа ихтэй байсан бол энэ төхөөрөмж “Агшин” нэвтрүүлэг дээр гардаг шиг хүрдийг эргүүлээд л болчихдог. Нохой болон сургагчийг залхаахгүй сайн талтай.

Манай улсын хувьд нохой сургалтын бүс нутаг хариуцсан олон улсын том төв болж хөгжих боломжтой. Ази, Европын дунд оршдог манай орны хувьд бусад улсаас дутмаг зүйл бол нохойн алба руу чиглэсэн төрийн нэгдсэн бодлого. Түүнчлэн илүү олуулаа болох хэрэгтэй. Нохой сонирхдог, энэ чиглэлээр ажиллахыг хүсдэг маш олон залуус байдаг ч ажлын орон тоо дутмаг. Бид Хөшигийн хөндийд олон улсын нохой сургалтын тоног төхөөрөмж болон аргагүйн стандартыг хангасан шинэ сургалтын төвтэй болж байгаа. Энэ төв баригдсанаар манайх хүний нөөцөө тэлж, илүү өргөн цар хүрээтэй ажиллана. Мөн бусад улстай хамтын ажиллагаа сайжирч, туршлага солилцох, хамтран ажиллах боломж бүрдэнэ гэж найдаж байна.

FINANCIAL TIMES СОНИНТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Үнэн бодит, найдвартай мэдээллийг түгээж уншигчдын итгэлийг хүлээсэн, дэлхийн тэргүүлэгч мэдээллийн агентлаг болох Financial Times нь жил бүр хүн төрөлхтөнд тулгамдсан асуудлыг шийдэхэд хандив босгох зорилгоор чиглэл бүрийн ашгийн бус байгууллагуудаас сонгож хамтран ажилладаг билээ.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Financial Times-ийн сонгосон байгууллагууд нийт 18 сая фунт стерлингийн хандив босгож чадсан нь сэтгүүлийн нийтлэлүүд хэр үр дүнтэй байдгийг харуулдаг.

2019 оны 8-р сарын 8-нд Financial Times нь ЛАСН-тай хамтран ажиллаж эхэллээ. Ингэхдээ зэрлэг амьтны хил дамнанас хууль бус худалдаатай тэмцэх ба ЛАСН-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гэрэл асаах зорилготой найман нийтлэл бичих юм.

Хамтын ажиллагааны хүрээнд Монголыг эхний нийтлэл бичих орноор сонгож зэрлэг амьтны хууль бус худалдааг эрэн сурвалжилж 2019 оны 11-р сарын 23-ны өдрийн дугаарт хэвлэжээ. Энэхүү нийтлэл Монгол орон хэрхэн зэрлэг амьтны эд эрхтэнг хууль бусаар дамжуулах орон болж буйг баримттайгаар харуулсан байна.


Үр дүнд нь зэрлэг амьтны хууль бус худалдааг таслан зогсоодог гол байгууллага болох Монгол улсын ГЕГ-ын үнэрч ноходын тоог өсгөх, мэргэжилтнүүдийн чадавхийг нэмэгдүүлэх зорилготой төсөл ЛАСН-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраар дамжин хэрэгжиж байна.



СОРГОГ

Сүүлийн жилүүдэд агнуур болон худалдаанд ихээр өртөж, тоо толгой нь цөөрч, ховордож буй 80 орчим зүйл амьтан, 21 зүйл ургамлын тархац, ховордлын үнэлгээ, хууль эрх зүйн орчин, худалддаг эд, эрхтний талаарх мэдээ, баримтыг багтаасан энэхүү аппликейшн нь хууль бусаар агнасан амьтны гаралтай эд, эрхтэн, бүтээгдэхүүнийг иргэд худалдан авч эрсдэлд орохоос сэргийлэхээс гадна хууль хяналтын ажилтнууд амьтдыг хялбар таньж, тодорхойлон хууль бус үйлдлийг таслан зогсооход туслах зорилготой.

Зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдааг бууруулахад хамтдаа зүтгэе!



Google Play Store болон Apple App Store-с “СОРГОГ” гэж хайгаад татаж суулгана уу.



ХАМТРАН АЖИЛЛАСАН ТА БҮХЭНДЭЭ чин сэтгэлийн ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ!

VfW

Английн “Зэрлэг амьтан хамгаалах ахмадын холбоо” (Veterans for wildlife)

Английн хавтгай хамгаалах сан (Wild Camel Protection Foundation UK)

АНУ-ын Үндэсний газарзүйн нийгэмлэг (National Geographic Society USA)

Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Булган сумын ЗДТГ, ИТХ

Булган сумын Нөхөрлөлүүдийн холбоо

ГЕГ-ын Эрэлч нохойн сургалтын төв

Гаяа амьтны хүрээлэн (Gaia Zoo)

ГИДЦГ-ын Орчны бүсийн сумдын ЗДТГ болон ИТХ:

Алтай, Цогт, Эрдэнэ, Баян-Өндөр, Шинэжинст

ГИДЦГ-ын Хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагч нар

Дарвины санаачилга сан (Darwin Initiative)

Дорноговь аймгийн ИТХ

Дорноговь аймгийн Цагдаагийн газар

ИБУИНВУ-ын Засгийн газрын Зэрлэг амьтны хууль

бус худалдааг бууруулах сорилын сан (Illegal Wildlife Trade Challenge Fund)

ИБУИНВУ-ын Монгол Улс дахь Элчин сайдын яам

ИБУИНВУ-ын Хилийн Алба (UK Border Force)

ЛАСН-ийн Лондон дахь төв байгууллага

Лийгэл Атлас

Монгол Улсын их сургууль

Монголын хавтгай хамгаалах сан

Монголын хараат бус судалгааны хүрээлэн

Монголын хүйсийн тэгш эрхийн төв

Монголын шувуу судлалын нийгэмлэг

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ИТХ

ЦЕГ-ын Экологийн цагдаагийн алба

Шинэ Зеландын Бээжин дэх Элчин сайдын яам

Эволюцын өвөрмөц, устаж байгаа зүйлийг

хамгаалах сан (EDGE foundation)

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

МОНГОЛ ХЭЛЭЭР

Адьяа, Я. 2017. Монгол орны хавтгай тэмээ (Camelus ferus przewalski, 1878)-ний экологийн зарим онцлог, хамгааллын асуудал. *Докторын ажил*. МУИС, ШУС, БУС. Улаанбаатар хот.

Адьяа, Я., Энхмаа, Э. 2016. *Монгол тарвага*. Улаанбаатар. Монгол.

Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ. Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт.

Вингард, Ж.Р., Паскуал, М., Рюд, А., Хоул, А., Конабой, Н., Батачарья, Г., Гомбобаатар, С., Мөнхжаргал, М., Мягмарсүрэн, Ш., Батсугар, Т., Болд, Т. 2017. *Зэлүүд тал-2: Нэгэн арваны дараах зэрлэг амьтны худалдааны хямрал*. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лийгэл Атлас, Хараат Бус Судалгааны Хүрээлэн. Лондон хот. ИБУИНВУ.

Гомбобаатар, С. 2012. *Монгол орны идлэг шонхор*. Улаанбаатар. Монгол.

Кларк, Э. Л., Мөнхбат, Ж., Дуламцэрэн, С., Baillie, J. E. М., Батсайхан, Н., Самъяа, Р., Stubbe, М. (эмхтгэгчид ба редакторууд). 2006. *Монгол Улсын хөхтөн амьтны Улаан данс. Бус нутгийн улаан дансны цуврал. Боть 1*. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот. Мягмарсүрэн, Д., Намхай, А. 2012. *Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд*. Мөнхийн үсэг. Улаанбаатар.

IN ENGLISH

BirdLife International. 2017. *Falco cherrug* (amended version of 2016 assessment). The IUCN Red List of Threatened Species 2017: e.T22696495A110525916. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2017-1.RLTS.T22696495A110525916.en>. Downloaded on 07 March 2021.

BirdLife International. 2020. *Aquila nipalensis*. The IUCN Red List of Threatened Species 2020: e.T22696038A180479129. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2020-3.RLTS.T22696038A180479129.en>. Downloaded on 07 March 2021.

Clayton, E. 2016. *Marmota sibirica*. The IUCN Red List of Threatened Species 2016: e.T12832A22258643. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2016-2.RLTS.T12832A22258643.en>. Downloaded on 07 March 2021.

Dudley, N. (2008). Guidelines for Applying Protected Area Management Categories. In S. Stolton, P. Shadie & N. Dudley (Eds.), (2013) *IUCN WCPA Best Practice Guidance on Recognising Protected Areas and Assigning Management Categories and Governance Types (Best Practice Protected Area Guidelines Series No. 21* ed., pp. x + 86). Gland, Switzerland: IUCN.

Gombobaatar, S. and Monks, E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors). 2011. *Regional Red List Series Vol.7. Birds*. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society.

Hare, J. 2008. *Camelus ferus*. The IUCN Red List of Threatened Species 2008: e.T63543A12689285. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2008.RLTS.T63543A12689285.en>.

Downloaded on 07 March 2021.

IUCN SSC Antelope Specialist Group. 2018. *Saiga tatarica*. The IUCN Red List of Threatened Species 2018: e.T19832A50194357. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2018-2.RLTS.T19832A50194357.en>. Downloaded on 07 March 2021.

Lucy, C. H., Samuel, D. M., Munkhzul, Ts., Tungalag, U., Anna, J., B. Nasanjargal, J. M. Rowcliffe. *A camera-trap study of mammalian waterhole use in the Inner Altai Gobi, Mongolia*.

Lucy, H. 2019. Drivers of mammalian activity patterns surrounding waterholes in the Mongolian Gobi Desert. *Master's thesis*. BIOS0014: MRes Biodiversity Research Project II. University of London.

McCarthy, T., Mallon, D., Jackson, R., Zahler, P. & McCarthy, K. 2017. *Panthera uncia*. The IUCN Red List of Threatened Species 2017: e.T22732A50664030. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2017-2.RLTS.T22732A50664030.en>. Downloaded on 07 March 2021.

MET/NACSO. 2018. *The state of community conservation in Namibia — a review of communal conservancies, community forests and other CBNRM activities (Annual Report 2017)*. MET/NACSO, Windhoek.

Nyambayar, B., Mix, H. & Tsytsulina, K. 2015. *Moschus moschiferus*. The IUCN Red List of Threatened Species 2015: e.T13897A61977573. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2015-2.RLTS.T13897A61977573.en>. Downloaded on 07 March 2021.

Umbaybayar, T., et al. (2019). *How Community-Based Rangeland Management Achieves Positive Social Outcomes In Mongolia: A Moderated Mediation Analysis*. *Land Use Policy*, **82**, 93-104. doi: <https://doi.org/10.1016/j.landusepol.2018.11.008>.

UNEP/CMS. 2017. Proposal for the inclusion of the steppe eagle (Aquila nipalensis) on Appendix I of the Convention on the conservation of migratory species of wild animals. *12th Meeting of the Conference of the Parties Manila, Philippines, 23 - 28 October 2017*. UNEP/CMS/COP12/Doc.25.1.13(a).

Wingard J.R. and P. Zahler. 2006. *Silent Steppe: The Illegal Wildlife Trade Crisis in Mongolia*. Mongolia Discussion Papers, East Asia and Pacific Environment and Social Development Department. Washington D.C.: World Bank.

WEBSITES:

About the Animals: Camels: <http://paleosleuths.org/camels.html>

Animal Diversity Web: https://animaldiversity.org/accounts/Falco_cherrug/

Animalia — All You Want to Know about Animals: <http://animalia.bio/>